



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 7 (436)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай  
(шинэчилсэн найруулга)*
- *Патентийн тухай (шинэчилсэн найруулга)*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *“Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр” батлах  
тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны хоёрдугаар сарын 21

№7 (436)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

102.	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай (шинэчилсэн найруулга)	157
103.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	164
104.	Патентийн тухай (шинэчилсэн найруулга)	164
105.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	174
106.	Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	174

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

107.	"Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр" батлах тухай	Дугаар 245	174
------	---	------------	-----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ (шинэчилсэн найруулга)

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж

2.1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "зохиогч" гэж өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагаагаар бүтээл туурвисан хувь хүнийг;

3.1.2. "эрх эзэмшигч" гэж утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотойгоор үүсэх зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг эдлэх хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.3. "уран бүтээлч" гэж утга зохиол, урлагийн болон ардын урлагийн бүтээлийг цирк, тайз, дэлгэц, урлагийн тоглолтод зориулан дуулах, хөгжимдөх, жүжиглэх, бүжиглэх, унших зэргээр гүйцэтгэн тоглодог хувь хүнийг;

3.1.4. "ардын урлагийн бүтээл" гэж ард түмний гүнц аливаа хэлбэрээр уламжлагдан дамжиж ирсэн, зохиогч нь тодорхойгүй уламжлалт утга зохиол, урлагийн бүтээлийг;

3.1.5. "фонограмм" гэж кино урлагийн, эсхүл дуу авиан дүрст бүтээлд

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

оруулснаас өөр аливаа тоглолтын болон бусад дуу авиа, түүний илэрхийллийн бичлэгийг;

3.1.6. "бүтээлийг хуулбарлах" гэж бүтээл, бүтээлийн хэсэг, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объектыг нэг буюу түүнээс дээш тоогоор шууд буюу шууд бусаар, аливаа арга, хэлбэрээр олшруулахыг;

3.1.7. "нийтлэх" гэж бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объектыг эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр, олон нийтийн хэрэгцээг хангахуйц хэмжээгээр олшруулж, нийтийн хүртээл болгохыг;

3.1.8. "нийтэд түгээх" гэж бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объектыг хэрэглэгч өөрийн сонгосон цаг, газраас хүртэх боломжтой байдлаар утсан болон утасгүй холбоогоор нийтэд тараахыг;

3.1.9. "үүсмэг бүтээл" гэж өмнө бүтээгдсэн бүтээлд тулгуур эж түүнийг оюуны бүтээлч хөдөлмөрөөр засварлах, найруулах, орчуулах, хөрвүүлэх, хураангуйлах, эмхтгэх болон бусад хэлбэрээр өөрчилж, шинээр бий болгосон бүтээлийг;

3.1.10. "хавсарга урлагийн бүтээл" гэж гар урлал болон үйлдвэрлэлийн аргаар бүтээгдсэн ахуйн хэрэглээний урлагийн бүтээлийг;

3.1.11. "зохиогчийн эрхэд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээл" гэж бүтээлийг шууд тоглосон тоглолт, дуу авиа, дүрс бичлэг, дуу авиа бүхий дүрст бүтээлийн анхны бичлэг болон радио, телевизийн байгууллагын нөвтрүүлгийг;

3.1.12. "фонограмм бүтээгч" гэж тоглолтын буюу бусад дуу авианы, эсхүл тэдгээрийн илэрхийллийн анхны бичлэгийг санаачлан хийсэн, бичлэгийн тухайд хариуцлага хүлээх хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.13. "дуу авиа бүхий дүрст бүтээл" гэж ямар материаллаар хэлбэрт оруулснаас үл шалтгаалан, техник хэрэгсэл ашиглан бүтээсэн дүрсийг дуу авианы хамт үзүүлэх боломжтой бүтээлийг;

3.1.14. "эрх эзэмшигчийн таних тэмдэг" гэж бүтээл, зохиогч, эрх эзэмшигч, тухайн бүтээлийг ашиглах нөхцөлийн талаар бүтээлд агуулагдсан, эсхүл бүтээлийг нийтэд түгээхтэй холбогдуулан тэмдэглэгдсэн мэдээлэл, эдгээр мэдээллийн тоон болон кодон илэрхийллийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Зохиогч, зохиогчийн эрхээр хамгаалах бүтээл 4 дүгээр зүйл. Зохиогчийн эрх эдлэх этгээд

4.1. Зохиогчийн эрхийг энэ хуулийн дагуу дараахь этгээд эдэлнэ:

4.1.1. Бүтээл нь нийтлэгдсэн эсэхээс үл хамаарч бүтээл туурвисан Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

4.1.2. Монгол Улсад бүтээлээ анх удаа нийтэлсэн гадаадын иргэн;

4.1.3. уран баримал, уран барилга, архитектур, хот байгуулалтын бүтээл болон барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг болох дүрслэх урлагийн бүтээлээ тус улсын нутаг дэвсгэрт байнга байршуулсан зохиогч;

4.1.4. зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийн дагуу зохиогчийн эрх эдлэх хуулийн этгээд;

4.1.5. Монгол Улсын олон улсын гэрээнд нэгдэн орсон бусад улсын иргэн, хуулийн этгээд.

4.2. Гадаадын иргэн бүтээлээ өөр улсад нийтэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор Монгол Улсад нийтэлсэн бол Монгол Улсад анх удаа бүтээлээ нийтэлсэнтэй адилтгаж үзнэ.

4.3. Зохиомол нэрээр болон нэргүйгээр хэвлэгдсэн бүтээлийн хувьд зохиогчийн эрхийг хуульд заасан этгээд эдэлнэ.

### 5 дугаар зүйл. Хамтарсан зохиогч

5.1. Нэг зорилготойгоор хамтын бүтээлч хөдөлмөрийн үр дүнд нэгдмэл бүтээл туурвисан хоёр буюу түүнээс дээш этгээдийг хамтарсан зохиогчид гэнэ.

5.2. Хамтарсан зохиогч бүхий бүтээлийн хувьд зохиогчийн эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол зохиогчид хамтран эдэлнэ.

### 6 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн бүтээл /объект/

6.1. Зохиогчийн эрхийн бүтээлд агуулга, зориулалт, үнэ цэнэ, ач холбогдол, илэрхийллийн оргаасаа үл шалтгаалан зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийг тооцно.

6.2. Зохиогчийн эрхийн бүтээлийг нийтлэгдсэн эсэхээс үл шалтгаалан бичмэл, аман, зурмал болон бусад биет хэлбэрээр бүтээсэн байна.

### 7 дугаар зүйл. Зохиогчийн эрхээр хамгаалах бүтээл

7.1. Дараахь бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаална:

7.1.1. шинжлэх ухаан, утга зохиолын бичмэл буюу аман бүх төрлийн бүтээл, түүнчлэн компьютерийн программ;

7.1.2. хөгжмийн урлагийн үгтэй болон үггүй бүх төрлийн бүтээл;

7.1.3. дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл;

7.1.4. чимэглэх болон хавсарга урлаг, тайз чимэглэлийн бүтээл;

7.1.5. архитектурын бүтээл, уран баримал, уран бичилгэ;

7.1.6. бүжгийн урлагийн бүх төрлийн бүтээл, уран нугаралт, пантомим;

7.1.7. жүжиг, хөгжимт жүжиг, тайзны урлагийн бүх төрлийн бүтээл;

7.1.8. гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл;

7.1.9. дуу авиа бүхий дүрст бүтээл;

7.1.10. үүсмэл бүтээл;

7.1.11. материалыг нь сонгон түүвэрлэх, байршуулах зэргээр бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон, өөрийн бүтээц агуулгаараа оюуны бүтээлд тооцогдох тайлбар толь, лавлах, зохиолын цоморлиг, өгөгдөхүүн-мэдээллийн сангийн бусад эмхтгэлүүд;

7.1.12. ардын урлагийн бүтээлд тулгуурлан туурвисан үүсмэл бүтээл.

## 8 дугаар зүйл. Зохиогчийн эрхээр үл хамгаалах бүтээл

8.1. Дараахь бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалахгүй:

8.1.1. хууль тогтоомж, эрх зүйн бусад акт;

8.1.2. захиргааны шийдвэр болон хуулийн этгээд, байгууллагын албан баримт бичиг;

8.1.3. шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамж болон бусад баримт бичиг, шүүх хуралдаан дээр хэлсэн үг;

8.1.4. энэ хуулийн 8.1.1-8.1.3-т заасан баримт бичгийн орчуулга;

8.1.5. төрийн бэлгэ тэмдэг, туг, далбаа, шагнал, одон, тэмдэг;

8.1.6. болсон үйл явдал, түүний үр дагавар болон тоо баримт бүхий сонордуулгын шинжтэй аливаа мэдээ, мэдээлэл;

8.1.7. ардын урлагийн бүтээл, үндэсний зан заншил;

8.1.8. аливаа санаа, үйл ажиллагааны арга, үйл ажиллагаа, шинжлэх ухааны нээлт, математикийн үзэл баримтлал.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Зохиогчийн эрх, түүний хугацаа

#### 9 дүгээр зүйл. Зохиогчийн эрх үүсэх, баталгаажих

9.1. Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийг бодитойгоор туурвиж бүтээсэн үеэс үүснэ.

9.2. Зохиогчийн эрх үүсэх болон түүнийг хэрэгжүүлэхэд баталгаажуулалт шаардахгүй.

9.3. Бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигч нь эрхээ нийтэд таниулах зорилгоор зохиогчийн эрх

хамгаалагдсаныг илэрхийлэх таних тэмдэг хэрэглэх эрхтэй.

9.4. Зохиогч болохыг нотлох баримтгүй тохиолдолд энэ бүтээл болон бүтээлийн хувь дээр бичигдсэн нэрийг зохиогч гэж тооцно.

9.5. Зохиогч хүсвэл өөрийн бүтээл, түүнтэй холбоотой бүтээл ашиглах онцгой эрхийг бусдад шилжүүлэх гэрээ, хэлцлийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "Оюуны өмчийн газар" гэх/-д сайн дурын үндсэн дээр бүртгүүлж болно.

9.6. Энэ хуулийн 9.3-т заасан таних тэмдгийг дараахь байдлаар илэрхийлж болно:

9.6.1. дугуй хүрээ бүхий латин "С" үсэг;

9.6.2. бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигчийн нэр;

9.6.3. бүтээлийг анх нийтэлсэн он.

#### 10 дугаар зүйл. Зохиогчийн эдлэх эрх

10.1. Зохиогч бүтээлийнхээ хувьд эдийн бус баялгийн эрх болон бүтээл ашиглах онцгой эрх эдэлнэ.

#### 11 дүгээр зүйл. Зохиогчийн эдийн бус баялгийн эрх

11.1. Зохиогч бүтээлийнхээ хувьд эдийн бус баялгийн дараахь эрх эдэлнэ:

11.1.1. бүтээлээ өөрийн болон зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтлэх;

11.1.2. зохиомол, нууц нэрийг түүний зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, задруулахыг хориглох;

11.1.3. бүтээлээ нийтлэх эсхүл бүтээлийг ашиглах тухай бүр нэрээ дурдуулах;

11.1.4. бүтээл болон түүний нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа арга хэлбэрээр хувиргах, гажуудуулах, өөрчлөхийг хориглох.

#### 12 дугаар зүйл. Бүтээл ашиглах онцгой эрх

12.1. Зохиогч нь өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах онцгой эрх эдэлнэ.

12.2. Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд зохиогч дараахь үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхийг хамааруулна:

12.2.1. бүтээлийг хуулбарлах;

12.2.2. бүтээлийг нийтлэх;

12.2.3. бүтээлийг нийтэд түгээх;

12.2.4. үүсмэл бүтээл болон өөрчлөх;

12.2.5. түрээсээр ашиглуулах.

12.3.Энэ хуулийн 12.1 дэх хэсэгт заасан эрхийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр, гэрээний үндсэн дээр бусад этгээдэд шилжүүлнэ.

### 13 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн хугацаа

13.1.Тодорхой бүтээлийн хувьд эдлэх зохиогчийн эрхийг хамгаалах хугацааг уг бүтээлийг туурвисан өдрөөс эхлэн тооцно.

13.2.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барснаас хойш 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

13.3.Зохиогчийн эдийн бус баялгийн эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална.

13.4.Зохиогч бүтээлээ зохиомол, нууц нэрээр буюу нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд уг зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлсний дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 75 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

13.5.Энэ хуулийн 13.4-т заасан бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хугацааг энэ хуулийн 13.2-т зааснаар тооцно.

13.6.Хамтын бүтээлийн зохиогчийн эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барсна дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 50 жилийн хугацаанд хамгаалагдана.

### 14 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийг өвлөх

14.1.Зохиогчийн бүтээлээ ашиглах онцгой эрхийг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу өв залгамжлана.

14.2.Хамтын бүтээл зохиогчдын бүтээлээ ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ.

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

#### Зарим бүтээлийн зохиогчийн эрхийн онцлог

### 15 дугаар зүйл. Үүсмэл бүтээлийн зохиогчийн эрх

15.1.Үүсмэл бүтээлийн зохиогчийн эрх нь эх бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүй бөгөөд энэ хуулийн 12.2.4-т заасан зөвшөөрөл авна.

15.2.Үүсмэл бүтээлийн зохиогчийн эрх нь эх бүтээлд тулгуурлан өөр зохиогч өөр үүсмэл бүтээл туурвихад саад болохгүй.

### 16 дугаар зүйл. Түүвэр зохиол, бусад эмхтгэл бүтээлийн зохиогчийн эрх

16.1.Эмхтгэгч нь эмхтгэлд орсон эх бүтээл бүрийн зохиогчийн эрхийг хөндөхгүй бөгөөд энэ хуулийн 12.2.4-т заасан зөвшөөрөл авна.

16.2.Эмхтгэлд орсон эх бүтээлийн зохиогч нь эмхтгэгчтэй хийсэн гэрээнд өөрөөр заагаагүй бол бүтээлээ тухайн эмхтгэлээс үл хамааран чөлөөтэй ашиглах эрхтэй.

### 17 дугаар зүйл. Албан үүргийн дагуу туурвисан бүтээлийн зохиогчийн эрх

17.1.Албан үүргийн дагуу бүтээл туурвисан зохиогч бүтээлийнхээ хувьд эдийн бус баялгийн эрх эдлэх эрхтэй.

17.2.Албан үүргийн дагуу туурвисан бүтээлийг ашиглах онцгой эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил олгогч эдэлж болно.

### 18 дугаар зүйл. Захиалгаар бүтээл туурвих

18.1.Захиалгаар туурвих бүтээлийн зохиогч захиалагчтай хийсэн гэрээний нөхцөлийн дагуу бүтээл туурвих захиалагчид хүлээлгэн өгөх, захиалагч нь гэрээнд заасан нөхцөлийн дагуу зохиогчид төлбөр төлөх үүрэгтэй.

18.2.Захиалгаар туурвисан бүтээлийг ашиглах онцгой эрхийг гэрээнд заасан этгээд эдэлнэ.

### ТАВДУГААР БҮЛЭГ

#### Зохиогчийн эрхэд хамаарах эрхийн хамгаалалт

### 19 дугаар зүйл. Зохиогчийн эрхэд хамаарах эрхийг эдлэх этгээд.

19.1.Зохиогчийн эрхэд хамаарах эрхийг энэ хуулийн дагуу дараахь этгээд эдэлнэ:

19.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт тоглолтоо хийсэн, нэвтрүүлсэн, тоглолтын анхны бичлэгээ хийсэн уран бүтээлч;

19.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт анх бичлэг хийсэн, нийтэлсэн фонограммын хувьд түүнийг бүтээгч;

19.1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт байрладаг дамжуулагчаас дамжуулсан нэвтрүүлгийн хувьд тус улсын нутаг дэвсгэрт байрладаг радио, телевизийн төв байгууллага;

19.1.4.Монгол Улсын олон улсын гэрээнд нэгдэн орсон бусад улсын иргэн, хуулийн этгээд.

19.2. Зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигч энэ бүлэгт заасан эрхийг эх бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүйгээр эдэлнэ.

19.3. Зохиогчийн эрхэд хамаарах эрх үүсэх, түүнийг хэрэгжүүлэхэд баталгаажуулалт шаардахгүй.

## 20 дугаар зүйл. Уран бүтээлчийн эрх

20.1. Уран бүтээлч нь өөрийн тоглолт, уран бүтээлийн хувьд дараахь үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхтэй:

20.1.1. тоглолт нь өмнө нэвтрүүлснээс бусад өөрийн бичлэгт ороогүй тоглолтыг нийтэд үзүүлэх нэвтрүүлэх, дамжуулах;

20.1.2. тоглолтонд бичлэг хийлгэх;

20.1.3. тоглолтын дуу, дүрс бичлэгийг хуулбарлах;

20.1.4. фонограммд буулгасан тоглолтын эх хувь болон хуулбарыг худалдах, эрх шилжүүлэх замаар нийтэд түгээх;

20.1.5. тоглолтын бичлэгийг түрээслүүлэх;

20.1.6. онцгой эрхээ бусдад гэрээгээр шилжүүлэх.

20.2. Уран бүтээлч нь тоглолтын хувьд тоглолтын гүйцэтгэгч гэж нэрлүүлэхийг шаардах, нэр хүндэд нь хохирол учруулахуйцаар өөрчлөх, гажуудуулахыг хориглох эдийн бус баялгийн эрх эдэлнэ.

20.3. Уран бүтээлчийн тоглолтын эрхийг хамгаалах хугацаа нь тоглолт болсон болон бичлэг хийгдсэн хугацаанаас хойш 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

## 21 дүгээр зүйл. Фонограмм бүтээгчийн эрх

21.1. Фонограмм бүтээгч нь өөрийн фонограммтай холбогдсон дараахь үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхтэй:

21.1.1. фонограммыг шууд буюу шууд бусаар хуулбарлах;

21.1.2. фонограммын эх хувь болон хуулбарыг худалдах эсхүл эрх шилжүүлэх замаар нийлгэх;

21.1.3. фонограммын эх хувь болон хуулбарыг түрээслүүлэх;

21.1.4. фонограммыг нийтэд түгээх;

21.1.5. онцгой эрхээ гэрээгээр бусдад шилжүүлэх.

21.2. Фонограмм бүтээгчийн эрхийн хамгаалалтын хугацаа нийтэлснээс хойш, нийтлээгүй бол бичлэг анх хийсэн хугацаанаас хойш 50 жил байна.

## 22 дугаар зүйл. Радио, телевизийн байгууллагын эрх

22.1. Радио, телевизийн байгууллага өөрийн нэвтрүүлэгтэй холбоотой дараахь үйл ажиллагааг хориглох болон зөвшөөрөх онцгой эрхтэй:

22.1.1. нэвтрүүлгийн бичлэг хийх;

22.1.2. нэвтрүүлгийн бичлэгийг хуулбарлах;

22.1.3. нэвтрүүлгийг утсан бус холбоо ашиглах замаар дахин дамжуулах;

22.1.4. нэвтрүүлгийг нэгэн зэрэг дамжуулах.

22.2. Радио, телевизийн байгууллагын нэвтрүүлгийн эрхийн хамгаалалтын хугацаа уг нэвтрүүлгийг анх нэвтрүүлсний дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах

## 23 дугаар зүйл. Бүтээл ашиглах онцгой эрхээ бусдад шилжүүлэх

23.1. Бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээний үндсэн дээр бүрэн буюу хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлж болно.

23.2. Зохиогчийн эрхийг шилжүүлэх гэрээнд дараахь зүйлийг тусгаж болно:

23.2.1. бүтээлийг ашиглах арга, хэлбэр;

23.2.2. хугацаа, хамрагдах нутаг дэвсгэрийн хүрээ;

23.2.3. бүтээлийг ашигласны төлбөрийн хэмжээ, төлөх журам, хугацаа;

23.2.4. зохиогчийн эрх, үүрэг;

23.2.5. бүтээлийг ашиглах этгээдийн эрх, үүрэг;

23.2.6. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлага;

23.2.7. маргаан шийдвэрлэх журам.

23.3. Бүтээлийг ашигласны төлбөрийн хэмжээ нь тухайн бүтээлийн шинж чанар, онцлог, ач холбогдол, бүтээлийг ашиглах хэлбэр, хэмжээ, хугацаа зэргээс хамааран хоёр тал хэлэлцэн тогтоосон мөнгөн дүнгээр буюу бүтээлийг гэрээнд заасан аргаар ашигласнаас олох ашгаас авахаар тохиролцсон байж болно.

23.4. Зохиогчийн эрхийг шилжүүлэх гэрээнд зохиогч хойшид тухайн сэдвээр буюу тухайн салбарт бүтээл туурвихыг хязгаарласан заалт оруулахыг хориглоно.

23.5. Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээний дагуу шилжүүлэн авсан этгээд

гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсний улмаас зохиогчийн эрх зөрчилдсөн бол зохиогч уг эрхээ сэргээхийг шаардах эрхтэй.

## 24 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийн зөрчилд тооцохгүй байх онцгой нөхцөлүүд

24.1. Нийтлэгдсэн бүтээлийн зүй ёсны ашиглалттай зөрчлдөөгүй, эрх эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр ашигласан дараахь тохиолдлыг зохиогчийн эрхийн зөрчилд тооцохгүй:

24.1.1. хэвлэлийн тойм бэлтгэх зорилгоор нийтлэгдсэн бүтээлээ ишлэл авах;

24.1.2. эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, шүүмжид болон мэдээллийн зорилгоор ишлэл авч хэсэгчлэн ашиглах;

24.1.3. архив, музей, номын санд ашиглагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн хуулбарлах;

24.1.4. эдийн засаг, улс төр, шашны холбогдолтой цаг үеийн асуудлаар сонин, сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэл, эфирт дамжуулсан бүтээлийг хуулбарлахыг тусгайлан хориглоогүй бол нийтэд мэдээлэх зорилгоор сонинд нийтлэх, эфирт дамжуулах, утсан болон утсан бус холбоогоор мэдээлэх;

24.1.5. хурал цуглаан дээр хэлсэн үг, илтгэлийг мэдээллийн зорилгоор нийтлэх;

24.1.6. болсон үйл явдлыг нийтэд мэдээлэхтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулсан уран барилга, дүрслэх урлаг, гэрэл зургийн бүтээлүүдийг тухайн орчны байдлыг үзүүлэх зорилгоор нийтлэх;

24.1.7. хараа болон сонсголын согогтой хүмүүсийн хэрэгцээнд зориулан ашиглах;

24.1.8. амины хэрэгцээнд зориулан бүтээлийг хуулбарлах;

24.1.9. эрүүгийн байцаан шийтгэх, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоор хуулбарлах.

24.2. Энэ хуулийн 24.1-д заасныг тодорхойлохдоо дараахь нөхцөлийг харгалзан үзнэ:

24.2.1. ашиг олох зорилгогүй байх;

24.2.2. бүтээлээс ашиглах хэмжээ болон ашигласан хэсгийн ач холбогдолтой шинж чанар;

24.2.3. бүтээлийн үнэ цэнэ, ашигласан хэсгийн зах зээл дэх үр нөлөө.

24.3. Энэ хуулийн 24.1-д зааснаар бүтээлийг ашиглахдаа зохиогчийн нэр, эх сурвалжийг заавал дурьдана.

## 25 дугаар зүйл. Интернетэд зохиогчийн эрхийг хамгаалах

25.1. Интернетийн үйлчилгээ түгээгч нь өөрийн серверт байршуулсан вэб хуудсанд

зохиогчийн эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогч болон эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

25.2. Интернетийн үйлчилгээ түгээгч нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдэгдсэн даруй тухайн вэб хуудсыг хаах үүрэг хүлээнэ.

25.3. Энэ хуулийн 25.1, 25.2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй интернетийн үйлчилгээ түгээгчид шүүгч, улсын байцаагч энэ хуульд заасан хариуцлага ногдуулна.

25.4. Вэб хуудсыг хаасантай холбоотой маргааныг шүүх шийдвэрлэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Зохиогчийн эрхийг хамгаалах байгууллага

#### 26 дугаар зүйл. Оюуны өмчийн газар

26.1. Зохиогчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг Оюуны өмчийн газар эрхлэн дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

26.1.1. зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

26.1.2. зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

26.1.3. зохиогч, зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, тэдний бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжих, зохиогчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

26.1.4. энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан хамтын удирдлагын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;

26.1.5. зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох, бүртгүүлсэн бүтээлийн сан байгуулах;

26.1.6. оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

26.1.7. зохиогчийн эрхийн зөрчлийг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, зохиогчийн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд навлагаа гаргаж өгөх;

26.1.8.зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах;  
26.1.9.ардын урлагийн бүтээлийг хамгаалах чиглэлээр иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах.

26.2.Оюуны өмчийн газар үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих бөгөөд үйл ажиллагааны хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

26.3.Оюуны өмчийн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

## 27 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллага

27.1.Зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид эрхээ хамгаалуулах зорилгоор, хамтын удирдлагын байгууллагыг байгуулан ажиллуулж болно.

27.2.Хамтын удирдлагын байгууллагыг зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчдийн санаачлагаар байгуулна.

27.3.Хамтын удирдлагын байгууллагыг зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн төрөл, ангиллаар дагнасан буюу хэд хэдэн төрлийг хамарсан үйл ажиллагаа явуулахаар байгуулж болно.

27.4.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа Оюуны өмчийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.

## 28 дугаар зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа

28.1.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчдийг төлөөлж, тэдний нэрийн өмнөөс, тэднээс олгосон бүрэн эрхийн хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна:

28.1.1.бүтээлийг нь ашиглуулах талаар гишүүн зохиогч болон эрх эзэмшигчтэй гэрээ байгуулах;

28.1.2.бүтээл ашиглах лиценз авсан этгээдтэй төлбөрийн хэмжээ, бусад нөхцөлийг тохиролцох, төлбөр авах;

28.1.3.авсан төлбөрөөс зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

28.1.4.гишүүн зохиогчийн бүтээлийг хууль бусаар ашигласан тухай мэдээллийн дагуу Оюуны өмчийн газарт санал тавьж шийдвэрлүүлэх, хуульд заасан арга хэмжээ авахуулах.

## 29 дүгээр зүйл. Хамтын удирдлагын байгууллагын үүрэг

29.1.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах талаар дараахь үүрэг хүлээнэ:

29.1.1.зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид бүтээл ашигласны шагналыг олгоходоо тухайн бүтээлийг ашигласантай холбогдолтой мэдээллийг танилцуулах;

29.1.2.лицензийн дагуу хураан авсан бүтээл ашигласны төлбөрийг зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

29.1.3.бүтээл ашигласантай холбогдуулан хураан авсан төлбөрөөс үйл ажиллагааны зардлыг хасч зохиогч, эрх эзэмшигчдэд тогтмол хугацаанд бүтээлийн ашиглалтын хэмжээгээр хувь тэнцүүлэн хуваарилах.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрх зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

#### 30 дугаар зүйл. Зохиогчийн эдийн бус баялгийн эрхийг хамгаалах

30.1.Бүтээлийн халдашгүй байдал болон зохиогчийн эдийн бус баялгийн бусад эрхийг зөрчсөн тохиолдолд зохиогч, зохиогч нас барсан бол түүний өв болон эрх залгамжлагч, хууль ёсоор буюу гэрээслэлээр өв залгамжлагч байхгүй, эдгээр өвлөгчид өв залгамжлахаас татгалзсан буюу тэдгээрийн өв залгамжлах эрх хасагдсан бол Оюуны өмчийн газар нь зөрчигдсөн эрхийг зохих журмын дагуу сэргээн тогтоохыг уг эрхийг зөрчсөн этгээдээс шаардах, шүүхэд гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

#### 31 дүгээр зүйл. Зохиогчийн эрх ба түүнд зохиогчийн эрхэд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

31.1.Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч иргэний нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гэм бууруутай иргэн, албан тухшаалтныг шүүгч 7-14 хоногоор баривчлах шийтгэл ногдуулж, улсын байцаагч, шүүгч нь эрчилтэй бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийг хураан авч, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгох буюу зохиогч болон зохиогчийн эрхэд



хамаарах эрх эзэмшигчид олгож, тухайн үйл ажиллагааг зогсооно.

31.2. Эрх эзэмшигчийн таних тэмдгийг хуурамчаар үйлдэж хэрэглэсэн, уг таних тэмдгийн хамт бичигдсэн зүйлийг өөрчилсөн, устгасан, хууль бусаар өөрчилсөн, устгасныг мэдсэн болон мэдэх боломжтой байсан ч түүнийг нэвтрүүлсэн, тараасан, тараах зорилгоор хилээр нэвтрүүлсэн, нийтэд түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох шийтгэл ногдуулна.

31.3. Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

31.4. Хэрэв эрх нь зөрчигдсөн зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигч хүсэлт гаргавал, түүнд зөрчилтэй бүтээгдэхүүнийг хохирлынх нь төлбөрт тооцож шилжүүлэн өгч болох бөгөөд хүсэлт гаргаагүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээг шүүгч, улсын байцаагч авна.

31.5. Зохиогчийн эрх зөрчиж, зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг хуулбарлахад ашигласан техник хэрэгслийг шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураан авч улсын орлого болгоно.

**32 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

32.1. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬ ХУЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1993 оны 6 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Зохиогчийн эрхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ПАТЕНТИЙН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Патентийн тухай хууль тогтоомж**

2.1. Патентийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.1.1. "шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг;

3.1.2. "бүтээгдэхүүний загвар" гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг;

3.1.3. "ашигтай загвар" гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг;

3.1.4. "патент" гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

3.1.5. "ашигтай загварын гэрчилгээ" гэж ашигтай загварыг эрх бүхий этгээд өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

3.1.6. "зохиогч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагаагаар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиосон хувь хүнийг;

3.1.7. "анхдагч огноо" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад анх хүлээн авсан он, сар, өдрийг;

3.1.8. "мэдүүлэг гаргагч" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын эрхийн хамгаалалт хийлгэж, патент буюу гэрчилгээ авахаар мэдүүлж байгаа зохиогч болон түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.9. "давамгайлах огноо" гэж мэдүүлгийнхээ анхдагч огнооноос өмнө Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн болон Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн аль нэг оронд уг шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг бүртгүүлэхээр мэдүүлсэн он, сар, өдрийг;

3.1.10. "патент, гэрчилгээ эзэмшигч" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент болон ашигтай загварын гэрчилгээ, үүнтэй холбоотой онцгой эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийг;

3.1.11. "шинжээч" гэж байгалийн болон техникийн ухааны дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт хоёроос доошгүй жил ажилласан, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий ажилтныг;

3.1.12. "төсөөтэй бүтээгдэхүүний загвар" гэж өмнө хамгаалагдсан бүтээгдэхүүний загвартай дийлэнх шинжээрээ төсөөтэй бүтээгдэхүүний загварыг;

3.1.13. "лиценз" гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ

бүхий ашигтай загварыг бусад этгээдэд ашиглуулах болзолтойгоор өгч байгаа зөвшөөрлийг;

3.1.14. "онцгой лиценз" гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ бүхий ашигтай загварыг патент, гэрчилгээ эзэмшигч нь гуравдагч этгээдэд нэгэн зэрэг ашиглуулахгүй байх болзолтойгоор, гэрээний үндсэн дээр бусдад ашиглуулах зөвшөөрлийг;

3.1.15. "албадан лиценз" гэж үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээ болон хуульд заасан бусад нөхцөлийн дагуу зохиогч буюу эрх эзэмшигчид зохих төлбөр төлж төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг бусад этгээдэд ашиглуулах зөвшөөрлийг;

3.1.16. "Монгол Улсын олон улсын гэрээ" гэж Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай 1883 оны Парисын конвенц, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай 1960, 1999 оны Гаагийн хэлэлцээр, Патентийн хамтын ажиллагааны 1970 оны гэрээ, Шинэ бүтээлийн олон улсын ангилал тогтоох тухай 1971 оны Страсбургийн хэлэлцээр, Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай 1968 оны Локарногийн хэлэлцээр, Дэлхийн худалдааны байгууллагын Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах 1994 оны хэлэлцээр болон Монгол Улсын нэгдэн орсон бусад олон улсын гэрээ, хэлэлцээрийг;

3.1.17. "Патентийн хамтын ажиллагааны гэрээнд нийцсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг" гэж давамгайлах огноо бүхий Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлгийг.

## 4 дүгээр зүйл. Шинэ бүтээлийн патент олгох зүйл, шалгуур

4.1. Шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой, үйлдвэрлэх шинэ арга ажиллагаа болон шинэ бүтээгдэхүүн зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно.

4.2. Техникийн тухайн үеийн түвшингээс давуутай нь нотлогдсон үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнийг "шинэ" гэж үзнэ.

4.3. "Шинэ бүтээлийн түвшин агуулсан" гэдэгт шинэ бүтээл нь холбогдох мэргэжлийн хүний хувьд ялгарах давуу шинж чанартайг шинжээч тогтоосон байдлыг ойлгоно.

4.4. Тухайн шинэ бүтээлийг үйлдвэрлэлийн аль нэг салбарт ашиглаж болохуйц байвал "үйлдвэрлэлд ашиглах боломжтой" гэж үзнэ.

4.5. Шинэ бүтээлийн шинэ байдлыг техникийн түвшний хувьд тогтоохын тулд оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /заашид "Оюуны өмчийн газар" гэх/-д тухайн шинэ бүтээлийн анхдагч огнооноос өмнө гаргасан мэдүүлэг болон эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, ашигтай загварын мэдээллийн баримтыг ашиглана.

4.6. Патентын шинжээч энэ хуулийн 4.1-д заасан шалгуурыг тогтооходоо Олон улсын урьдчилсан шүүлтийн байгууллагаас шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч болно.

4.7. Дараахь зүйлийг шинэ бүтээлд тооцохгүй:

4.7.1. нээлт, шинжлэх ухааны онол, математикийн арга;

4.7.2. компьютерийн программ, алгоритм;

4.7.3. аж ахуйн үйл ажиллагаа, оюуны үйлдэл, тоглоом зэрэгт хамаарах хуваарь, дүрэм, аргачлал;

4.7.4. нийгмийн дэг журам, зан суртахуун, байгаль орчин, хүний эрүүл мэндэд харш шийдэл;

4.7.5. хүн, мал, амьтны эмчилгээ, оношилгооны арга;

4.7.6. бичил биетээс бусад амьтан, ургамал болон тэдгээрийг гаргаж авах биологийн арга.

4.8. Энэ хуулийн 4.2-т заасан "шинэ" гэсэн шалгуурт тухайн бүтээлийг илэрхийлж байгаа шинж чанарууд нь мэдүүлгийн анхдагч огноо хүртэл нийтэд илэрхий болоогүй байх нөхцөлийг хамааруулна.

4.9. Энэ хуулийн 4.7.6-д биологийн бус болон микробиологийн үйл ажиллагаа хамаарахгүй.

## 5 дугаар зүйл. Бүтээгдэхүүний загварын патент олгох шалгуур

5.1. Бүтээгдэхүүний загвар нь шинэ, гоёл чимэглэлийн болон өвөрмөц шинжтэй бол зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно.

5.2. Бүтээгдэхүүний загварыг хамгаалахад дараахь шинж чанаруудыг харгалзан үзнэ:

5.2.1. бүтээгдэхүүний загварын шинж чанарууд нь мэдүүлгийн анхдагч огноо хүртэл нийтэд илэрхий болоогүй бол түүнийг "шинэ" гэж үзнэ;

5.2.2. бүтээгдэхүүний загварын шинж чанарууд нь оюуны бүтээлч шинжийг агуулж байвал түүнийг "өвөрмөц шинжтэй" гэж үзнэ;

5.2.3. бүтээгдэхүүний загварын шинж чанарт тухайн бүтээгдэхүүний гадаад шинжийн гоо зүйн болон зохицох онцлог шинж чанарыг хамааруулна.

5.3. Тухайн бүтээгдэхүүний загварт хамаарах шийдэл нь бүтээгдэхүүний үндсэн зориулалтад хамаарах бол патент олгохгүй

5.4. Дараахь шийдлийг бүтээгдэхүүний загварт тооцохгүй:

5.4.1. төрийн сүлд, туг, далбаа, тамга, шагнал, одон тэмдэг болон гадаад орны төрийн далбаа, бэлгэ тэмдэг, олон улсын байгууллагын тэмдэг, бэлгэдэлтэй ижил, төсөөтэй загвар;

5.4.2. нийгмийн ашиг сонирхол, ёс суртахуунд харш бол;

5.4.3. бусад этгээдийн бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулахаар бол.

## 6 дугаар зүйл. Ашигтай загварын гэрчилгээ олгох зүйл, шалгуур

6.1. Ашигтай загвар нь шинэ, үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой бол зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд гэрчилгээ олгоно.

6.2. Техникийн тухайн үеийн түвшингээс давуутай нь нотлогдсон ашигтай загварыг "шинэ" гэж үзнэ.

6.3. Ашигтай загвар нь үйлдвэрлэлийн аливаа салбарт ашиглаж болохуйц байвал "үйлдвэрлэлд ашиглах боломжтой" гэж үзнэ.

6.4. Ашигтай загварын шинж чанарууд нь мэдүүлгийн анхдагч огноо хүртэл нийтэд илэрхий болоогүй бол түүнийг "шинэ" гэж үзнэ.

6.5. Дараахь зүйлийг ашигтай загварт тооцохгүй:

6.5.1. ашигтай загварыг бүртгэхээс өмнө Монгол Улсад тухайн шийдэл нийтэд илэрхий болсон болон нэвтэрч ашиглагдсан;

6.5.2. урьд нь тус улсад болон гадаад оронд хэвлэн нийтлэгдсэн;

6.5.3. нийгмийн ашиг сонирхол, ёс суртахуунд харш шийдэл.

6.6. Энэ хуулийн 4.7 дахь хэсгийн заалт ашигтай загварын гэрчилгээ олгоход нэгэн адил хамаарна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх**

**7 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах**

7.1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд Оюуны өмчийн газарт гаргана.

7.2. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар бүрд тусдаа мэдүүлэг гаргах бөгөөд нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварт нэг мэдүүлэг гаргаж болно.

7.3. Шинэ бүтээлийн мэдүүлэг нь өргөдөл болон дараахь агуулга бүхий шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол, товч тайлбараас бүрдэх бөгөөд шаардлагатай бол өргөдөлд холбогдох зураг, болон эрх бүхий байгууллагын магадлагааг хавсаргана:

7.3.1. шинэ бүтээлийн тодорхойлолт нь шинэ бүтээлээр дэвшүүлсэн зорилгод хүрэхэд тухайн шийдлийн өмнөх техник, технологийн түвшингээс онцгой ялгарах шинэ чанар, хамаарах салбарын мэргэжлийн хэрэглэгчдэд түүний давуу байдал болон шинэ бүтээлийг ашиглах хамгийн тохиромжтой аргыг хангалттай, бүрэн ойлгомжтой гаргасан цогц мэдээллийг агуулна;

7.3.2. шинэ бүтээлийн томъёолол нь тухайн шинэ бүтээлийн онцгой ялгарах шинэ чанар, эрхийн хамгаалалтын хүрээг тогтоосон, ойлгомжтой, товч, тодорхой байх бөгөөд нэг шинэ бүтээл нь нэг буюу хэд хэдэн томъёололтой байж болно;

7.3.3. тодорхойлолт, зураг нь томъёоллын агуулгыг дэлгэрэнгүй тайлбарлана;

7.3.4. товч тайлбар нь тухайн шинэ бүтээлийн талаар мэдээлэл өгөх зорилготой бөгөөд түүнийг шинэ бүтээлийн эрхийн хамгаалалтын хүрээг тогтооход ашиглахгүй.

7.4. Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг нь өргөдөл, бүтээгдэхүүний загварын зураг, тодорхойлолтоос бүрдэх бөгөөд шаардлагатай бол зураг, тодорхойлолтод холбогдох бусад материалыг хавсаргана.

7.5. Ашигтай загварын мэдүүлэг нь өргөдөл, тодорхойлолт, томъёолол, тайлбар, зургаас бүрдэх бөгөөд ашигтай загварын томъёолол нь уг шийдлийн ялгарах шинжийг тодорхойлж, эрхийн хамгаалалтын хүрээг тогтооно.

7.6. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын өргөдөлд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч, мэдүүлэг гаргагч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, патент авах хүсэлт, шинэ

бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын нэрийг тусгана.

7.7. Зохиогч бус этгээд мэдүүлэг гаргах бол патент, гэрчилгээ авах эрхээ нотолсон баримтыг хавсаргана.

7.8. Хүн амын хүнсний хангамж, эрүүл ахуйтай холбогдсон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухайд хүний эрүүл мэнд, биед хохирол учруулахгүй нотолсон эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын магадлагаа, тодорхойлолтыг хавсаргана.

7.9. Мэдүүлэг гаргагч өргөдөлдөө үндэсний, бүсийн, олон улсын мэдүүлгийн огноог давамгайлах огноогоор тогтоолгох тухай хүсэлтээ илэрхийлж болох бөгөөд энэ тохиолдолд давамгайлах огноо хүсэж гаргасан мэдүүлгийн хуулбарыг хавсаргана.

7.10. Давамгайлах огноо тогтоолгох хүсэлт гаргахад шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэгт олон улсын хайлт, урьдчилсан шүүлтийн дүгнэлтийг хавсаргана.

7.11. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэгт үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

7.12. Мэдүүлэг гаргагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.

7.13. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг Иргэний хуульд заасан шаардлага хангасан итгэмжлэлээр тодорхойлно.

7.14. Мэдүүлгийг монгол хэлээр үйлдэх бөгөөд өөр хэлээр үйлдсэн тохиолдолд мэдүүлэг гаргагч Оюуны өмчийн газарт уг мэдүүлгийг ирүүлсэн өдрөөс хойш 2 сарын дотор монгол хэлнээ хөрвүүлж өгнө.

7.15. Энэ хуулийн 7.14-т заасан хугацаанд мэдүүлгийг хөрвүүлж өгөөгүй бол мэдүүлэг гаргаагүй гэж үзнэ.

7.16. Олон улсын нэг ангилалд хамаарах адил төстэй 50 хүртэл бүтээгдэхүүний загварыг нэг мэдүүлгээр мэдүүлж болно.

7.17. Мэдүүлэг гаргагч мэдүүлгийн талаар эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд мэдүүлгээ буцаан авч болно.

**8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах**

8.1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг мэдүүлэг гаргагч цахим хэлбэрээр гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд мэдүүлэг нь энэ хуулийн 7 дугаар зүйл, Оюуны өмчийн газраас баталсан журамд заасан шаардлага хангасан байна.

8.2. Энэ хуулийн 8.1-д заасан мэдүүлгийг уян диск болон мэдээллийн цахим хэлбэрийн бусад хэрэгслээр ирүүлж болно.

8.3. Цахим хэлбэрээр ирүүлсэн мэдүүлгийн анхдагч огноог тухайн мэдүүлэг энэ хуульд заасан шаардлагыг хангасан бөгөөд шаардлагатай баримтуудыг хавсаргасан нөхцөлд хүлээн авсан холбогдох ажилтны гарын үсэг, дугаар бүхий баримтыг үндэслэн тогтооно.

8.4. Цахим хэлбэрээр ирүүлсэн мэдүүлэгтэй холбоотой шийдвэрийг Оюуны өмчийн газар цахим хэлбэрээр хүргүүлж, тус газрын дарга цахим гарын үсэг хэрэглэж болно.

## 9 дүгээр зүйл. Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах

9.1. Монгол Улсыг нэр зааж гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын олон улсын мэдүүлгийн анхдагч огноог энэ хуулиар, эсхүл Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу бүртгүүлсэн олон улсын байгууллагын бүртгэлийн огноогоор тогтооно.

9.2. Монгол Улсын иргэн болон Монгол Улсад оршин суудаг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний гаргасан олон улсын мэдүүлгийн хувьд хүлээн авагч байгууллага нь Оюуны өмчийн газар болон Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага байна.

9.3. Мэдүүлэг гаргагч олон улсын мэдүүлгийг хүлээн авагч байгууллагад гэрээнд заасан хэл дээр гаргаж, хураамж төлнө.

9.4. Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтэй Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ авахаар Монгол Улсыг нэр заасан бол Оюуны өмчийн газар нь нэр заагдсан байгууллага болно.

9.5. Мэдүүлэг гаргагч нь олон улсын мэдүүлэгтэй олон улсын урьдчилсан магадлан шүүлт хийлгэхээр Монгол Улсыг сонгосон бол Оюуны өмчийн газар сонгогдсон байгууллага болно.

9.6. Сонгогдсон байгууллага нь мэдүүлэгт хийх урьдчилсан магадлан шүүлтийн тайланг

гэрээнд заасан хугацаанд хүлээж авна.

9.7. Монгол Улсыг сонгосон олон улсын мэдүүлгийн хувьд мэдүүлэг гаргагч Патентийн хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу урьдчилсан магадлан шүүлт хийж эхлэхээс өмнө хураамж төлнө.

9.8. Оюуны өмчийн газар олон улсын мэдүүлэгт хийх бүх үйл ажиллагааг холбогдох хууль, гэрээ, журмын дагуу гүйцэтгэнэ.

## 10 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох

10.1. Оюуны өмчийн газар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш 20, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн бөгөөд мэдүүлгийн бүрдэл хангасан гэж үзвэл анхдагч огноог мэдүүлэг хүлээн авсан өдрөөр тооцно.

10.2. Оюуны өмчийн газар мэдүүлгийг энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл түүнд нэмэлт, засвар хийх шаардлагатайг мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

10.3. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.2-т заасан мэдэгдлийг Оюуны өмчийн газар хүлээн авсан өдрөөс хойш шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт 3 сар, ашигтай загварын мэдүүлэгт 1 сарын дотор нэмэлт, засвар хийж ирүүлсэн тохиолдолд тухайн мэдүүлгийн анхдагч огноог мэдүүлгийг анх хүлээн авсан өдрөөр тооцно.

10.4. Энэ хуулийн 10.3-т заасан хугацааны дотор нэмэлт, засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг гаргагчид гэж үзнэ.

10.5. Мэдүүлэг гаргагч давамгайлах огнооны эрх хүсэж байгаа бол мэдүүлгийг бүртгэснээс хойш 2 сарын дотор энэ тухайгаа бичгээр мэдэгдэж, анхны мэдүүлгийн хуулбарыг ирүүлнэ.

## 11 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх

11.1. Мэдүүлгийн анхдагч огноог тогтоосны дараа Оюуны өмчийн газрын шинэжсэн тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар энэ хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан эсэхэд мөн чанарын шүүлт хийнэ.

11.2. Мэдүүлэг гаргагч мэдүүлсэн шинэ бүтээл, эсхүл түүнтэй мөн чанараараа ижил бүтээлд патент буюу өөр ямар нэг эрхийн баримт авахаар гадаадын улс, олон улсын байгууллагад

мэдүүлэг гаргасан тухайгаа Оюуны өмчийн газарт мэдэгдэнэ.

11.3. Шүүлт хийх явцад буюу эцсийн шийдвэр гарахаас өмнө мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр, мэдүүлэгтээ нэмэлт, өөрчлөлт хийж болно.

11.4. Нэмэлт, өөрчлөлт нь мэдүүлж байгаа шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мөн чанарыг өөрчлөх бол шинээр мэдүүлэг гаргана.

11.5. Мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр шүүлт хийхийг хойшлуулж болох боловч шүүлт хийхийг хойшлуулах хугацаа нь энэ хуулийн 11.9, 11.10-т заасан хугацаагаар хязгаарлагдана.

11.6. Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр мэдүүлгээ 2 буюу түүнээс олон мэдүүлэг болгон салгах, эсхүл хамтаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын хэд хэдэн мэдүүлгийг нэгтгэж болно.

11.7. Энэ хуулийн 11.6-д заасан тохиолдолд мэдүүлгийн анхдагч огноо буюу давамгайлах огноог анхны мэдүүлгээр тогтооно.

11.8. Шинэ бүтээлээр дэвшүүлсэн шийдлийн зохиогч мэдүүлгийг эцсийн шийдвэр гарахаас өмнө ашигтай загварын мэдүүлэг болгон, ашигтай загварын гэрчилгээ хүссэн мэдүүлгийг шинэ бүтээлийн мэдүүлэг болгон тус тус өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд анхдагч огноог анхны мэдүүлгээр тогтооно.

11.9. Оюуны өмчийн газар мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргана.

11.10. Оюуны өмчийн газар шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 11.9-д заасан хугацааг 12 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

11.11. Патент олгохоор шийдвэрлэсэн шинэ бүтээлийн ном зүй, томъёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентийн хэвлэлд нийтэлж зарлана.

11.12. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болох нь нотлогдоогүй, хамгаалах боломжгүй бол патент олгохоос татгалзсан шийдвэр гаргах бөгөөд шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг дүгнэлт гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор мэдүүлэг гаргагчид хүргүүлж, мэдүүлгийг патентийн санд хадгална.

**12 дугаар зүйл. Ашигтай загварын мэдүүлэгт магадлан шүүлт хийх**

12.1. Мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 1 сарын дотор энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан эсэх, ашигтай загвараар бүртгэгдэх боломжтой эсэхэд шинжээч магадлан шүүлт хийж дүгнэлт гаргана.

12.2. Ашигтай загварын мэдүүлэгт шүүлт хийхэд энэ хуулийн 11.2, 11.3-т заасныг нэгэн адил мөрдөнө.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

**Патент, ашигтай загварын гэрчилгээ олгох**

**13 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент олгох**

13.1. Шинэ бүтээлийн ном зүй, томъёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентийн хэвлэлд нийтэлсэн өдрөөс хойш 3 сарын дотор Оюуны өмчийн газарт няцаасан нотолгоо ирээгүй, маргаан гараагүй бол патент олгоно.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан хугацаанд няцаасан нотолгоо ирсэн, маргаан гарсан тохиолдолд тэдгээрийг зохих журмын дагуу шийдвэрлэх хүртэл патент олгохыг хойшлуулна.

13.3. Иргэн, хуулийн этгээд няцаасан нотолгоо ирүүлсэн, маргаан гарсан тохиолдолд Оюуны өмчийн газрын ерөнхий шинжээч гомдол хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор анхны шинжээчийг оролцуулалгүйгээр 3 шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр тухайн маргааныг дахин хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд анхны шинжээчид гаргасан дүгнэлтээ нотлох боломж олгоно.

13.4. Энэ хуулийн 13.3-т заасны дагуу гарсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан таслах комисст гомдлоо гаргаж болно.

13.5. Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг улсын бүртгэлд бүртгэж, мэдүүлгийг нь патентийн санд хадгална.

**14 дүгээр зүйл. Ашигтай загварын гэрчилгээ олгох**

14.1. Ашигтай загвараар бүртгэх боломжтой гэж шинжээчийн дүгнэлт гарсан өдрөөс хойш 1 сарын дотор Оюуны өмчийн газар ашигтай загварын гэрчилгээ олгоно.

**15 дугаар зүйл. Патент, ашигтай загварын гэрчилгээний хүчинтэй байх хугацаа**

15.1. Анхдагч огнооноос эхлэн шинэ бүтээлийн патент 20 жил, бүтээгдэхүүний загварын патент 10 жил, ашигтай загварын гэрчилгээ 7 жилийн хугацаанд тус тус хүчинтэй байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн эрх**

**16 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогчийн эрх**

16.1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч дараахь эрх эдэлнэ:

16.1.1. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвараа өмчлөх;

16.1.2. патент, гэрчилгээ авах эрхээ бусад этгээдэд шилжүүлэх;

16.1.3. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвартаа нэр өгөх;

16.1.4. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын технологийн баримт бичиг боловсруулах, тэдгээрийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд оролцож, хяналт тавих, оюуны бүтээлээ үнэлэх;

16.1.5. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглаж олсон бусад этгээдийн орлогоос зохих хэмжээний төлбөр авах.

16.2. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар хамтран бүтээсэн зохиогчид патент авах эрхийг хамтран эдэлнэ.

16.3. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг болон техникийн баримт бичиг бүрдүүлэх, санхүүжүүлэх, туршилт хийх зэргээр туслалцаа үзүүлсэн этгээдийг хамтран зохиогч гэж тооцохгүй.

16.4. Хамтран зохиогчид гэрээнд өөрөөр заагаагүй бол мэдүүлэг гаргах, патент, гэрчилгээ авах, бүтээлээ ашиглуулах, бусад этгээдэд худалдах, шилжүүлэх, үнэлэх болон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвартай холбоотой харилцаанд тэгш эрх эдлэх бөгөөд хэн нэг нь бусад хамтран зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа эрх эдлэхгүй.

16.5. Ижил шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг тусдаа бүтээсэн бол Оюуны өмчийн газарт түрүүлж мэдүүлэг өгсөн зохиогч, харин давамгайлах огноо мэдүүлсэн тохиолдолд эхэлж давамгайлах огноотой мэдүүлэг өгсөн зохиогч патент, гэрчилгээ авах эрх эдэлнэ.

16.6. Албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад

бүтээсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварт гэрчилгээ авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил олгогч эдэлнэ.

16.7. Ажил олгогч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг бүтээснээс хойш 6 сарын дотор мэдүүлэг гаргаагүй бол зохиогч нь мэдүүлэг гаргах эрх эдэлнэ.

16.8. Энэ хуулийн 16.7-д зааснаар зохиогч өөрийн нэр дээр патент, гэрчилгээ авсан тохиолдолд ажил олгогч тухайн бүтээлийг ашиглахдаа патент, гэрчилгээ эзэмшигчид гэрээний үндсэн дээр зохих төлбөр төлнө.

**17 дугаар зүйл. Патент, гэрчилгээ эзэмшигчийн эрх**

17.1. Патент, гэрчилгээ эзэмшигч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвараа өмчлөх онцгой эрх эдэлнэ.

17.2. Патент, гэрчилгээ бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг патент, гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрлөөр ашиглана.

**18 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглах**

18.1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, хэрэглэх болон энэ зорилгоор хадгалах, гадаадаас оруулахыг патент, гэрчилгээ эзэмшигч хориглох эрхтэй.

18.2. Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болон гэрчилгээ бүхий ашигтай загварыг дараахь байдлаар ашиглавал эрх эзэмшигчийн онцгой эрхийг зөрчсөн гэж үзэхгүй:

18.2.1. патент эзэмшигч өөрөө, эсхүл түүний зөвшөөрөлтэйгээр бусад этгээд тус улсын зах зээлд гаргасан бүтээгдэхүүнийг ашиглах;

18.2.2. эрдэм шинжилгээ, сургалт, туршилтын ажилд ашиглах;

18.2.3. тус улсын нутаг дэвсгэрт түр болон тохиолдлоор орж ирсэн бусад орны тээврийн хэрэгсэлд ашиглах;

18.2.4. ашиг олох зорилгогүйгээр ашиглах.

18.3. Оюуны өмчийн газар эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг үр дүнтэй ашиглах зорилгоор шинэ бүтээлийн улсын нөөцийн сан бий болгоно.

18.4. Энэ хуулийн 18.3-т заасан санг бүрдүүлж байгаа бүтээлийн патент эзэмших эрхийг

Оюуны өмчийн газар патент эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эдэлнэ.

### 19 дүгээр зүйл. Лицензийн гэрээ

19.1. Сонирхогч этгээд патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ бүхий ашигтай загварыг ашиглах тохиолдолд патент, гэрчилгээ эзэмшигчтэй лицензийн гэрээ байгуулна.

19.2. Лицензийн гэрээгээр патент, гэрчилгээ эзэмшигч нь хамгаалагдсан бүтээлийг ашиглах зөвшөөрлийг бүтээл ашиглагчид олгох, бүтээл ашиглагч гэрээгээр тогтоосон төлбөр төлөх болон гэрээгээр тодорхойлсон бусад үүрэг хүлээнэ.

19.3. Лицензийн гэрээнд дараахь зүйлийг тусгана:

19.3.1. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглах арга, хэлбэр, хэмжээ, хүрээ, хугацаа;

19.3.2. гэрээний талуудын эрх, үүрэг;

19.3.3. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашигласны төлбөрийн хэмжээ, түүнийг олгох журам;

19.3.4. гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлага;

19.3.5. маргаан шийдвэрлэх журам.

19.4. Онцгой лиценз өгөх тохиолдолд лиценз өгөгч нь лиценз авагчид шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглах онцгой эрхийг лицензийн гэрээний дагуу олгоно.

19.5. Энгийн лиценз өгөх тохиолдолд лиценз өгөгч нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг лиценз авагчид ашиглуулахаар өгөх, патент, гэрчилгээгээр олгогдсон эрхээ гуравдагч этгээдэд нэгэн зэрэг ашиглуулах эрхтэй байна.

19.6. Лицензийн гэрээг бичгээр үйлдэх бөгөөд Оюуны өмчийн газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

19.7. Энэ хуулийн 19.6-д заасан журмыг зөрчсөн гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

19.8. Патент эзэмшигч өөрийн бүтээлээ сонирхогч этгээдэд ашиглуулах лиценз олгох тухай хүсэлтээ Оюуны өмчийн газарт гаргаж болно.

19.9. Лицензийн гэрээг шударга өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлтэйгээр байгуулахыг хориглоно.

### 20 дугаар зүйл. Албадан лиценз хэрэглэх

20.1. Эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг сонирхогч этгээдийн хүсэлт, Оюуны өмчийн газрын шийдвэрээр дараахь тохиолдолд албадан лицензээр ашиглаж болно:

20.1.1. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан ашиглах;

20.1.2. мэдүүлгийн анхдагч огнооноос хойш дөрвөн жил өнгөрсөн, эсхүл патент, гэрчилгээ олгосон огнооноос хойш 3 жилийн турш ашиглаагүй үед бүтээлийг ашиглах нөхцөл байгаагүй эрх эзэмшигч нотолж чадаагүй бол;

20.1.3. лицензийн гэрээгээр патент олгосон бүтээлийг ашиглаж байгаа байдал нь шударга бус өрсөлдөөний шинжийг агуулсан гэж патент эзэмшигч үзвэл.

20.2. Патент, гэрчилгээ эзэмшигч албадан лиценз хэрэглэх тухай Оюуны өмчийн газрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдол гаргаж болно.

20.3. Албадан лиценз хэрэглэх гэрээ байгуулах нөхцөлд патент, гэрчилгээ бүхий бүтээл ашигласны төлбөрийг лиценз авагч нь патент, гэрчилгээ эзэмшигчид төлнө.

### 21 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар ашиглах хуулийн этгээд болон патент эзэмшигчийн үүрэг

21.1. Хуулийн этгээд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашигласнаас олсон ашиг, оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж, үйлдвэрлэлийн нууцыг нь хадгална.

21.2. Оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг хөрөнгийн баталгаа, барьцаа, хөрөнгө оруулалт, хувьцаа гаргах, хувьчлал болон дуудлагын худалдаанд оруулах, дүрмийн сан бүрдүүлэх, даатгалд хамруулах зэрэгт хэрэглэж болно.

21.3. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигч өөрчлөгдөхөд энэ тухай бичгээр Оюуны өмчийн газарт мэдэгдэх бөгөөд энэ өөрчлөлт нь гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөхгүй.

### 22 дугаар зүйл. Улсын нууцад холбогдох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар

22.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах үйл ажиллагаанд хамаарах онц



чухал, маш нууц, нууц зэрэглэлд хамаарах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг тагнуулын төв байгууллагад бүртгүүлсний дараа Оюуны өмчийн газрын ерөнхий шинжээч хүлээн авч, нууц бүтээлд хайлт, шүүлт хийх эрх бүхий шинжээчид шилжүүлэн дүгнэлт гаргуулж, патент олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

22.2. Улсын нууцад хамаарах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг хэвлэлд нийтлэхгүй.

## 23 дугаар зүйл. Патент, лицензийн хураамж

23.1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, патентийг хүчинтэй байлгах, лицензийн гэрээг бүртгүүлэх хураамжийг Оюуны өмчийн газарт төлнө.

## 24 дүгээр зүйл. Патентийн хураамж төлөх хугацаа

24.1. Патентийг хүчинтэй байлгах хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээ, хугацаагаар төлнө.

24.2. Патентийг хүчинтэй байлгах эхний 3 жилийн хураамжийг энэ зүйлийн 24.2-т заасан өдрөөс хойш 6 сарын дотор, дараах хугацааны хураамжийг тухайн хугацаа эхлэхээс 6 сарын өмнө тус тус төлнө.

24.3. Патент эзэмшигч патентийг хүчинтэй байлгах хураамжийг энэ зүйлийн 24.2-т заасан хугацаанд төлөөгүй бол Оюуны өмчийн газар тухайн хугацаа өнгөрснөөс хойш 6 сарын хөнгөлөлтийн хугацааг тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд тухайн хугацааны хураамжтай тэнцэх хэмжээний төлбөр нэмж төлнө.

24.4. Патентийг хүчинтэй байлгах сонирхол бүхий этгээд патент эзэмшигчийн зөвшөөрлөөр патентийн хураамжийг төлж болно.

## 25 дугаар зүйл. Патентийг хүчингүйд тооцох

25.1. Энэ хуульд заасныг зөрчиж патент, гэрчилгээ олгосон байвал маргаан шийдвэрлэх комисс, шүүх патентийг хүчингүй болгоно.

25.2. Патент эзэмшигчээс болон патентийн хураамж төлөхөөс татгалзсан, хураамжийг энэ хуулийн 24.3 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд Оюуны өмчийн газар патентийг хүчингүй болгоно.

25.3. Энэ хуулийн 25.1, 25.2-т заасан тохиолдолд Оюуны өмчийн газар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулж, патентийн хэвлэлд нийтэлнэ.

25.4. Шинэ бүтээлийг огт ашиглаагүй тохиолдолд тухайн шинэ бүтээлийг Монгол Улсад ашиглах нөхцөл байгаагүйг патент эзэмшигч нотлох чадаагүй бол төрийн хяналтад зайлшгүй байх шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг эзэмших эрх Оюуны өмчийн газарт шилжинэ.

25.5. Патентийг хүчингүй болгох тухай хүсэлтийг патент хүчинтэй байх хугацаанд гаргана.

25.6. Патентийн хураамжийг төлөөгүй шалтгаанаар патентийг хүчингүйд тооцсон нөхцөлд патент хүчинтэй байх нийт хугацааны дотор патент эзэмшигчийн хүсэлтээр патентийг сэргээж болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Оюуны өмчийн байгууллага

## 26 дугаар зүйл. Оюуны өмчийн газар

26.1. Монгол Улсад шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмчийн газар хариуцан дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

26.1.1. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авч, хянан шийдвэрлэх;

26.1.2. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ олгох;

26.1.3. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, лицензийн гэрээний улсын бүртгэл хөтлөх;

26.1.4. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

26.1.5. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухай мэдээллийг хэвлэн нийтлэх;

26.1.6. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвартай холбогдсон маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай лавлагаа гаргаж өгөх;

26.1.7. патент, ашигтай загварын гэрчилгээний загварыг тогтоох;

26.1.8. хуулийн этгээд, иргэдийг Патентийн тухай хууль зөрчсөн гэж үзвэл холбогдох байгууллагад мэдэгдэх;

26.1.9. хуульд заасан үндэслэл, журмын дагуу патент, гэрчилгээг хүчингүйд тооцох;

26.1.10. патентийн хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрх хэмжээнийхээ хүрээнд зохион байгуулах;

26.1.11. патентийн асуудалтай холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

26.1.12. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын үнэлгээг зохиогчийн хүсэлтээр баталгаажуулах;

26.1.13. оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

26.1.14.эрхлэх асуудлаар байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт бичгийг гаргуулж авах;

26.1.15.оюуны өмчийн сургалт, судалгааны ажлыг нэгдсэн удирдамж, арга зүйгээр хангах;

26.1.16.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах иргэн, хуулийн этгээдийг шалгаруулах, тэдгээртэй хамтран ажиллах;

26.1.17.хуулиар харьяалуулсан маргааныг хянан шийдвэрлэх.

26.2.Оюуны өмчийн газар үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжинэ.

26.3.Оюуны өмчийн газраас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

26.4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын ажлыг технологийн бодлогынхоо бүрэлдэхүүн хэсэг болгон явуулна.

## 27 дугаар зүйл. Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

27.1.Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, ял шийтгэлтгүй, 25 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна.

27.2.Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгч холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл авна.

27.3. Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг Оюуны өмчийн газар батална.

27.4.Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын төлөөллийн үйл ажиллагааны тайланг Оюуны өмчийн газарт ирүүлэх бөгөөд үйлчилгээний хөлсний 10 хувийг Оюуны өмчийн газарт өгнө.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**28 дугаар зүйл. Гомдол, маргаан шийдвэрлэх**

28.1.Эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээлийг хууль бусаар ашигласнаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, бүтээл ашигласны төлбөр гаргуулахтай холбогдон үүссэнээс бусад маргааныг Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан

шийдвэрлэх комисс гомдлыг хүлээн авснаас хойш 6 сарын дотор хянан шийдвэрлэж, хариуг бичгээр мэдэгдэнэ.

28.2.Маргаан шийдвэрлэх комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

28.3. Маргаан шийдвэрлэх комиссын ажиллах журмыг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**29 дүгээр зүйл. Патентийн тухай хууль тогтоомж, зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

29.1.Патентийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

29.1.1 шүүгч, улсын байцаагч иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.2.шүүгч гэм буруутай иргэн, албан тушаалтныг 7-14 хоногоор баривчлах;

29.1.3.улсын байцаагч, шүүгч зөрчилтэй бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийг хураан авч, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгон, тухайн барааг устгаж, үйл ажиллагааг зогсоох.

29.2.Зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг зөрчсөн этгээд Монгол Улсын хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

29.3.Патент эзэмшигчийн эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх асуудлыг Монгол улсын Иргэний хуулийн дагуу шүүх шийдвэрлэнэ.

**30 дугаар зүйл. Хуулийг буцаан хэрэглэх**

30.1. Энэ хуулийг буцааж хэрэглэхгүй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1993 оны 6 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Патентийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцусгай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Патентийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хуульд заасан зөрчил гаргасан" гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй бол зөрчил гаргасан" гэж өөрчилсүгэй.

"Банк бус санхүүгийн үйл ажиллагаа, Банкны тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай болон Газрын тухай хууль тогтоомж" гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

### "Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр" батлах тухай

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, Үндэсний хөтөлбөрийг 2006-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1 дүгээр шатны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг жил бүр батлуулж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн дарга Ц.Элбэгдоржид даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийг салбар, орон нутгийнхаа хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардагдах

хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж олон улсын байгууллага, хандивлагчдын эзэл, тусламжийг чиглүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Байгаль орчны сайд У.Барсболд, Эрүүл мэндийн сайд Т.Ганди, Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Т.Гандид даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Т.ГАНДИ

Засгийн газрын 2005 оны 245 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

### "ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

#### Нэг. Нийтлэг үндэслэл

Орчны эрүүл мэндийн асуудал нь нэг улс, бүс нутаг, тивийн хүрээнээс хальж, дэлхий нийтийг хамарсан орчин үеийн тулгамдсан асуудлын нэг болсон бөгөөд тэдгээрийг оновчтой шийдвэрлэх нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мянганы хөгжлийн зорилтод хүрэх тулгуур нөхцөл болох юм.

Хүний эрүүл мэнд, амьдралын чанар нь хүрээлэн байгаа орчны физик, хими, биологи, нийгэм

болон сэтгэл зүйн хүчин зүйлээр тодорхойлогддог бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага "орчны эрүүл мэнд гэдэгт өнөөгийн болон хойч үеийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох орчны хүчин зүйлийг тодорхойлох, үнэлэх, хянах, тандах болон урьдчилан сэргийлэх онол практикийн цогц үйл ажиллагаа орно" гэж тодорхойлсон байна.

Дэлхийн олон улс оронд сүүлийн жилүүдэд хүрээлэн байгаа орчны хими, физик, биологийн

бохирдолт ихсэж энэ нь хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна. Буурай хөгжилтэй улс орнуудад аюулгүй ундны усны хангамжийн дутагдал, эрүүл ахуй ариун цэврийн хангалтгүй нөхцөл, гэр сууцны галлагаанаас шалтгаалсан агаарын бохирдол зэрэг орчны эрсдэлт хүчин зүйлүүд хүн амын эрүүл мэндэд ихээр нөлөөлж байхад эдийн засгийн өндөр хурдтай хөгжиж байгаа улс орнуудад хотжилт болон үйлдвэржилтээс шалтгаалсан агаар, ус, хөрсний бохирдол, үйлдвэрлэлийн осол ихээр нэмэгдэж байна. Номхон далайн бүсийн улс орнуудад ариун цэврийн тааламжгүй нөхцөл, ундны усны чанар, хангамж, гэрийн доторхи агаарын бохирдол зэргээс шалтгаалсан өвчнөөр жилд дунджаар 580 мянган хүн нас барж байгаагаас гадна хот, суурин газрын агаарын бохирдол болон химийн бодисын хордлогоор жил бүр 405 мянган хүн нас барж байна.

Орчны бохирдол нь хүн амын өвчлөлийг 20.0-30.0 хувиар нэмэгдүүлж байна. Тухайлбал, агаарын бохирдолт нь хорт хавдар, амьсгалын замын эмгэг, зүрх судасны өвчин, эмгэг үүсэхэд зонхилох хүчин зүйл болж байна. Мөн хүүхдийн дархлалтын түвшинг бууруулан бие бялдрын өсөлт хөгжилтийн зохистой харьцааг алдагдуулах, хүүхэд дутуу болон төрөлхийн гажигтай төрөхөд нөлөөлж байгааг судлаачид тогтоожээ. Хүрээлэн байгаа орчны бохирдолт нь хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй шууд болон шууд бусаар улс орны эдийн засаг, хөгжил дэвшилд асар их хохирол саад учруулж байна. Хүн амын эрүүл мэндэд орчны бохирдолтоос шалтгаалж учруулсан хохирол нь зөвхөн Европын холбооны улсуудад жилд 20 сая ам. доллараар тооцогдож байгааг судлаачид тооцоолон гаргасан байна.

Монгол орны хувьд хөдөөгийн болон нийслэл хотын захын хорооллын хүн ам баталгаатай цэрвэ ундны усаар бүрэн хангагдаж чадаагүй, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан орчин бүрдээгүйн зэрэгцээ төв суурин газрын орчны бохирдол жилээс жилд нэмэгдэж байна.

Улсын хэмжээнд ашиглаж байгаа бохир ус цэвэрлэх байгууламжийн 46 нь буюу 60.8 хувь нь зөвхөн усыг бүрэн цэвэрлэхгүй, эсвэл огт ажиллахгүй байна. Зөвхөн Улаанбаатар хотод оногт үйлдвэр, ахуйн хэрэглээнээс гарч байгаа 180.0 орчим мянган шоометр бохир ус бүрэн цэвэрлэгдэхгүйгээр Туул голд нийлж байна. Гэр хорооллын 70.0 гаруй мянган бие засах энгийн жорлон, бохир усны цооног нь хөрсний биологийн бохирдолтын гол эх үүсвэр болж байна.

Томоохон хотуудын агаарын бохирдолтын байдалд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс 2003-2004 онуудад хийсэн судалгааны дүнгээс үзэхэд хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх химийн хортой бодис болох азотын давхар исэл 1.5 дахин, нүүрстөрөгчийн дутуу исэл 4.2 дахин, тоосны агууламж нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 7.8 дахин хэтэрсэн байна.

Улаанбаатар хотын цахилгаан станц их, бага айрын уурын зууханд жилдээ 4.0 сая тонн нүүрс, өйл өрхүүд ердийн халаалттай орон сууцны галлагаанд 400 гаруй мянган тонн нүүрс, 300.0 гаруй мянган шоометр мод тус тус хэрэглэж байгаагаас гадна 70 гаруй мянган автомашинь хаягдал утаа, тортог, үнсээр агаар, хөрс, орчны бохирдуулж байна. Агаарын бохирдолт ихтэй Улаанбаатар хотод амьдарч байгаа багц насны хүүхдүүд хөдөө орон нутгийн хүүхдүүдээс бронхит өвчнөөр 1.4-2.7 дахин, гуурсан хоолойн багтраа өвчнөөр 5.5-7.9 дахин илүү өвчлж байна.

Монгол Улсын хэмжээнд 2002 онд явуулсан химийн бодисын үзлэг тооллогын дүнгээс үзэхэд ургамал хамгаалах, ахуйн шавьж, мэргэж амьтныг устгах, халдваргүйжүүлэх зорилгоор жилд "онцгой хортой" 14.4 тонн, "хортой" 735.4 тонн химийн бодис хэрэглэгдэж байгаагийн 20.3 тонн нь озоны давхаргыг задлах бодис байна.

Сүүлийн жилүүдэд орчны бохирдолтыг багасгах талаар зарим арга хэмжээг авч байгаа боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Орчны эрүүл мэндийн хяналтын тогтолцоо шаардлагын хэмжээнд хүрээгүй, хууль, эрх зүйн орчин боловсронгуй бус, мэргэжлийн боловсон хүчний хангамж, чадавхи хангалтгүй, лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний түвшин зохих хэмжээнд хүрээгүй, орчны эрүүл мэндийн чиглэлээр хийгдэж байгаа судалгаа, шинжилгээний ажлын тоо хэмжээ, нэр төрөл, чар хүрээ бага, санхүүжилт нь хангалтгүй байна.

Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж өвчин, эмгэгт хүргэж байгаа орчны хүчин зүйлийг судлах, түүний шалтгаан, үр дагаврыг арилгах, орчны нөлөөлөөс сэргийлэх цэгцтэй арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх зорилгоор орчны эрүүл мэндийн талаар Засгийн газраас хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөрийг боловсруулахад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан орчны эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвшилцөр болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн заалтыг мөрдлөг болголоо.

Энэхүү хөтөлбөр нь ойрын 10 жилийн хугацаанд орчны эрүүл мэндийн талаар Засгийн газраас баримтлах бодлогыг тодорхойлж, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын 7, 11, 12, 13, 14 дүгээр заалт, Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх стратегийн баримт бичиг болно.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зарчим

Хөтөлбөрийн зорилго нь хүрээлэн буй орчныг бохирдуулж байгаа хүчин зүйлийг багасгах, орчны эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулах

замаар хүн амыг эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

- НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилт, ДЭМБ-ын болон олон улсын бусад байгууллагын зорилттой уялдуулах;
- Орчныг бохирдолтоос хамгаалах, бохирдолтыг багасгах, хүн амын өвчлөл, осол гэмтлийг бууруулах арга хэмжээг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд үндэслэн нотолгоонд тулгуурлан хэрэгжүүлэх;
- Орчны бохирдолтыг бууруулах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, хувь хүний оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Орчны бохирдолтыг бууруулах үйл ажиллагаанд салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах;
- Орчны эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг уялдуулж, нөөцийг оновчтой хуваарилж, хандивлагч, олон улсын байгууллагуудын тусналцаа, дэмжлэг, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

## Гурав. Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааны чиглэл

*Зорилт 1. Орчны эрүүл мэндэд тавих хяналт, тандалт, үнэлгээний тогтолцоо, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.*

Үйл ажиллагааны чиглэл:

1.1. Орчны эрүүл мэндийн талаархи хууль тогтоомж, дүрэм, зааврыг шинэчлэх;

1.2. Орчны эрүүл мэндэд хяналт тавих, тандалт, судалгаа хийх эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;

1.3. Орчны эрүүл мэндийн чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаа, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ өгөх;

1.4. Орчны эрүүл мэндийн чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах.

Хүрэх үр дүн:

- Орчны эрүүл мэндийн талаархи хууль эрх зүйн актууд шинэчлэгдэнэ;
- Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны үр дүн сайжирна;
- Орчны эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр салбар дундын хамтын ажиллагаа нэгдсэн удирдлага зохицуулалттай болж нөөцийн хуваарилалт оновчтой болно.

*Зорилт 2. Орчноос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлд дүн шинжилгээ хийх, үнэлэх, хянах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.*

Үйл ажиллагааны чиглэл:

2.1. Орчны бохирдолтын талаархи эрүүл мэндийн статистик үзүүлэлтийг боловсронгуй болгон мэдээллийн сантай болох;

2.2. Орчны бохирдлын тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, Шинжлэх ухаан, технологийн сан болон бусад эх үүсвэрээс судалгаа шинжилгээний ажилд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх;

2.3. Төв, суурин газрын орчныг бохирдуулж байгаа эх үүсвэр, бохирдлын шалтгаан, хүчин зүйлд төрөлжсөн судалгаа хийж үнэлгээ өгөх;

2.4. Хүн амын эрүүл мэндийн байдлыг орчны хүчин зүйлтэй холбон судалж, үнэлгээ өгөх;

2.5. Орчны эрүүл мэндийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

2.6. Орчны эрүүл мэндийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох.

Хүрэх үр дүн:

- Орчны бохирдолтын түвшин болон орчноос хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийн талаар судалгаа шинжилгээ хийгдсэн байна;
- Орчны эрүүл мэндийн талаархи мэдээллийн тогтолцоо бий болсон байна;
- Орчны эрүүл мэндийн чиглэлээр үндэсний боловсон хүчний чадавхи сайжирсан байна;
- Орчны эрүүл мэндийн чиглэлээр хяналт, судалгаа шинжилгээ хийх лабораторийн хүчин чадал сайжирсан байна.

*Зорилт 3. Орчны бохирдолтыг бууруулан жолоогийн тэнцвэртэй байдлыг хангах, орчны сөрөг хүчин зүйлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.*

Үйл ажиллагааны чиглэл:

3.1. Хот, суурин газрын төлөвлөлт, хот байгуулалтын экологийн менежментийг боловсронгуй болгох;

3.2. Орчны бохирдолтыг багасгах, түүний шалтгаан, үр дагаврыг арилгахад чиглэсэн дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх;

3.3. Хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, гэр, орон сууцны агаарыг цэвэршүүлэх дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх;

3.4. Хөдөөгийн болон хотын захын хорооллын хүн амын цэвэр усны хангамжийг нэмэгдүүлэх;

3.5. Суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, цэвэрлэх байгууламжийн төлөвлөлт, ашиглалтыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагаа явуулах;

3.6. Орчны химийн бодисоор бохирдуулж байгаа эх үүсвэрийг тогтоох, хортой, хаягдал химийн бодисыг байгаль орчин, хүн ам, ургамал, амьтанд халгүйгээр устгах, цэвэршүүлэх цогц арга хэмжээ авах.

Хүрэх үр дүн:

- Хот, суурин газарт агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэн үр дүнг тооцсон байна;
- Хөдөөгийн болон хотын захын хорооллын хүн амын цэвэр усны хангамж нэмэгдэж, чанар нь сайжирсан байна;
- Хот, суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо нэмэгдсэн байна;
- Аюултай хортой бодис, пестицидийн хяналтын менежмент сайжирсан байна.

*Зорилт 4. Хүн амд орчны эрүүл мэндийн талаархи зохистой мэдлэг, дадал, хандлага, зан үйл хэвшүүлэх замаар орчны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.*

Үйл ажиллагааны чиглэл:

4.1. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт орчны эрүүл мэндийн чиглэлээр мэдлэг, боловсрол олгох асуудлыг тусгах;

4.2. Хүн амын дунд явуулах экологи, орчны болон нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглах, албан ба албан бус сургалтыг явуулах;

4.3. Эрүүл орчин бүрдүүлэхэд чиглэсэн хамт олны санаачилгыг дэмжин эрүүл хот, дүүрэг, сум, ажлын байр, сургууль болох хөдөлгөөнийг хөгжүүлэх.

Хүрэх үр дүн:

- Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгагдсан нийгмийн болон орчны эрүүл мэндийн сургалтын агуулга өргөжиж сургалтын цаг нэмэгдэнэ;
- Орчны эрүүл мэндийг дэмжсэн хөтөлбөр, үйл ажиллагаанд хамт олны оролцоо дээшилнэ;
- Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо нэмэгдэнэ;
- Орчны эрүүл мэндийн талаархи мэдлэгийн түвшин дээшилнэ.

**Дорov, Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Үндэсний хэмжээнд

Хөтөлбөрийн хэрэгжилтийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулж бусад хөтөлбөр төсөлд оролцогч гадаад, дотоодын талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг Засгийн газарт тайлагнах үүрэг гүйцэтгэнэ.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг Эрүүл мэндийн яам гүйцэтгэх бөгөөд холбогдох яамдын асуудал хариуцсан мэргэжилтнийг оролцуулан энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий орон тооны бус ажлын бүлэг байгуулж ажиллуулна.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг төсвийн тооцооны хамт гарган Засгийн газраар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Орон нутгийн түвшинд

Аймаг, нийслэлийн Засаг даргаар ахлуулсан Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл нь орон нутгийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, биелэлтийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлд тайлагнах үүрэг гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа, уялдаа холбоо

Орчны эрүүл мэнд хөтөлбөр нь Усны үндэсний хөтөлбөр, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөр, Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө болон орчны эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа бусад төсөл, хөтөлбөртэй уялдаж хэрэгжинэ.

**Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

б/хандивлагч орон, НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын байгууллагын хандив, тусламж;

в/гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл;

г/төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө;

д/бусад эх үүсвэр.

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа, үе шат**

Хөтөлбөрийг 2015 он хүртэл дараахь 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат 2006 - 2010 он;

Хоёрдугаар үе шат 2010 - 2015 он.

## Долоо. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

Хөтөлбөрийн хяналт, үнэлгээг Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ үнэлгээний газар гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох яамдыг оролцуулж болно. Үнэлгээний тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлд жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан танилцуулна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хөтөлбөрийн зорилт тус бүрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт болон үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтээр гаргана.

Хөтөлбөрийн эцсийн үр дүнг дараахь үзүүлэлтээр гаргана:

- Орчны эрүүл мэндийн талаархи хууль эрх зүйн орчин шинэчлэгдэж, хяналт, танадалт, үнэлгээний тогтолцоо боловсронгуй болсон байна;

- Орчныг бохирдуулагч эх үүсвэр, шалтгаан, хүчин зүйл тогтоогдож, орчны бохирдол, эрүүл мэндийн хамаарлын үнэлгээ гарсан байна;

- Орчны эрүүл мэндийн салбарын хүний нөөц, лабораторийн чадавхи сайжирсан байна;

- Хүн амын орчны болон нийгмийн эрүүл мэндийн боловсролын түвшин дээшилж, орчны эрүүл мэндийг дэмжсэн хөтөлбөр, үйл ажиллагаанд хамт олны оролцоо нэмэгдсэн байна;

- Хот, суурин газрын орчны бохирдолтыг илтгэх суурь үзүүлэлт одоогийн түвшингээс сайжирсан байна (Хүснэгт1);

- Орчны бохирдлоос шууд шалтгаалах хүн амын өвчлөлийн түвшин буурсан байна (Хүснэгт 2).

Хүснэгт 1

### Хот суурин газрын орчны бохирдолтын суурь үзүүлэлт

Агаарын бохирдолтын үзүүлэлт

/2004 оны байдлаар/

Үзүүлэлт	Жилийн дундаж мг/м3
Хүхрийн давхар исэл(SO <sub>2</sub> )	0.012
Азотын давхар исэл(NO <sub>2</sub> )	0.026

Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн 2004 оны шинжилгээний дүн

### Ус түгээх байрны ундны усны бохирдолтын үзүүлэлт

/2004 оны байдлаар/

Үзүүлэлт	Дундаж агууламж
1 мл усанд агуулагдах нянгийн ерөнхий тоо	100-с их
Гэдэсний савханцрын таньц	300 мл усанд 3-с их
Нитрит (мг/л)	0.006-0.004
Аммиак (мг/л)	0.02-0.137
Ерөнхий хатуулаг (мг/экв/л)	1.28-2.1
РН	6.6-7.1

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын лабораторийн 2004 оны шинжилгээний дүн

Улаанбаатар хотын хөрсний бохирдлын үзүүлэлт

/2004 оны байдлаар/

Үзүүлэлт	Дундаж агууламж
1 гр хөрсөнд агуулагдах нянгийн ерөнхий тоо	1 127 000
Гэдэсний савханцрын таньц	0.26
Перфрингенсийн таньц	0.11
Аммикийн агууламж (%)	0.55
Нитритийн агууламж (%)	0.0027
Нитратын агууламж (%)	0.2
Хар тугалгын агууламж (мг/кг)	49.92

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын лабораторийн 2004 оны шинжилгээний дүн

Хүснэгт 2

### Орчны бохирдлоос шалтгаалах өвчлөлийн үзүүлэлт

/2004 оны байдлаар/

Өвчний нэр	10000 хүн амд ногдох үзүүлэлт
Гэдэсний халдварт өвчин	
Балнад	0.06
Сальмонелёз	0.79
Цусан суулга	8.79
Гепатит А	20.79
Амьсгалын дээд замын үрэвсэлт өвчин	
Цочмог төвөнхтөс, мөгөөрсөн хоолойтос	265.9
Гуурсан хоолойн багтраа	2.9

Эрүүл мэндийн яам, "Эрүүл мэндийн үзүүлэлт" товхимол 2004 он

Засгийн газрын 2005 оны 245 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## "ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 1 ДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Оролцох байгууллага	Хугацаа
Нэг. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар:				
1	Ариун цэврийн тухай, Байгаль орчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулах	БОЯ, УМХГ	ХЗДХЯ, холбогдох яам	2006-2007
2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн асуудлыг тусгах	БОЯ, ЭМЯ	ХЗДХЯ, УМХГ	2006-2007
3	ДЭМБ-ын үндэсний усны чанарын Ш гарын авлагыг үндэслэн үндэсний стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх арга хэмжээ авах	ЭМЯ	УМХГ, БОЯ	2006 - 2010
4	ДЭМБ-аас боловсруулсан агаарын чанарын гарын авлагыг үндэслэн хот, суурин газрын агаарын чанарын үндэсний стандартыг шинэчлэн боловсруулах	ЭМЯ	УМХГ	2006 - 2010
5	Ажлын байрны агаарын стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	ЭМЯ, НХХЯ	ҮХЯ, ТЭХЯ, УМХГ	2007
6	Барилга байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн нормыг шинэчлэх	БХБЯ	ЭМЯ, УМХГ	2006 - 2007
7	Хүрээлэн байгаа орчин, ажлын байрнд дахь химик, физик, биологийн хүчин зүйлийн зөвшөөрөгдөх хэмжээг шинэчлэн тогтоох	ЭМЯ, БОЯ	Холбогдох яам	2007-2008
8	Орчны дуу шуугиан, цахилгаан соронзон орны стандартыг шинээр боловсруулж мөрдүүлэх	ЭМЯ, БОЯ	УМХГ	2007
9	Эрүүл ахуйн урьдчилсан хяналтын дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	УМХГ	БХБЯ, ЭМЯ	2007
10	Үйлдвэр, аж ахуйн нэгжээс гарч байгаа хаягдал дахь орчныг бохирдуулах хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээг шинэчлэх	БОЯ, ЭМЯ	ҮХЯ, ТЭХЯ, ЗТАЖЯ	2007
11	Хүрээлэн байгаа орчныг бохирдуулж байгаа үйлдвэр, аж ахуйн газарт нөхөн төлбөр ногдуулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх	БОЯ, УМХГ	ҮХЯ, холбогдох яам	2006-2007
12	"Орчны эрүүл мэнд" сан байгуулах асуудлыг судлах	ЭМЯ, БОЯ	СЯ	2007-2008
13	Нийгмийн эрүүл мэндийн тэнцэлт, судалгаа, үнэлгээний тогтолцоо бий болгох асуудлыг судлах	УМХГ, ЭМЯ	Холбогдох яам	2007-2008
14	Нийгмийн эрүүл мэнд, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах	УМХГ	Холбогдох яам	2006-2010
15	Аймаг, орон нутгаас орчны бохирдолтын асуудлаар авдаг статистикийн үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулах	ЭМЯ, УСГ, БОЯ	Холбогдох яам, агентлагууд	2007-2009



16	Орчны эрүүл мэндийн талаар мэдээллийн сан бий болгох	ЭМЯ, БОЯ, УСГ	Холбогдох яам, агентлагууд	2007-2010
Салбар дундын хамтын ажиллагааг хангах талаар:				
17	Орчны эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэргжилтийн талаар салбар дундын уулзалт, зөвлөлтөөн зохион байгуулж аяндаа холбоог сайжруулах	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл	Холбогдох яам, агентлагууд	2006-2010
18	"Орчны эрүүл мэнд" Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар үндэсний болон бүсийн семинар, зөвлөлтөөн зохион байгуулан цаашид авах арга хэмжээг эрчимжүүлэх	ЭМЯ, БОЯ, УМХГ	Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ	2007-2010 жил бүр
19	Орчны эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлээр төсөл боловсруулан олон улсын байгууллага, хандивлагч орнуудад тавьж шийдвэрлүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах	ЭМЯ, БОЯ, БХБЯ, УХЯ	Холбогдох яам, агентлагууд	2007-2010
Хоёр. Орчноос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлд дүн шинжилгээ хийх, үнэлэх, хянах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар:				
1	Орчны эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр хийгдэж байгаа судалгаа, үнэлгээний ажлын аргачлалыг боловсронгуй болгох	ЭМЯ, БОЯ, УХЯ, НХХЯ	Холбогдох яам	2007-2010
2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, нөлөөллийн үнэлгээг гэрээгээр гүйцэтгэх журам тогтоон хэрэгжүүлэх	ЭМЯ, БСШУЯ, ШУТС, УМХГ	Холбогдох яам	2007-2010
3	Орчны эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлээр 2007-2010 онд Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр гүйцэтгүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тодорхойлох	ЭМЯ, БСШУЯ, ШУТС	БОЯ, УМХГ	2007 он
4	Төв, суурин газрын орчныг бохирдуулж байгаа эх үүсвэр, физик, хими, биологийн хүчин зүйлийн дэлгэрэнгүй жагсаалт, зураглал гаргах	УМХГ, БОЯ, УХЯ, ТЭХЯ, ЗТАЖЯ	Бусад яам	2007-2009
5	Хүрээлэн байгаа орчноос хамааралтай, хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийн судалгааг аймаг, хотоор гаргах	ЭМЯ	УМХГ, БОЯ	2007-2008
6	Хотын дуу шууган, цахилгаан соронзон орны түвшинд тандалт судалгаа хийж зураглал гаргах, хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх	ЭМЯ, БСШУЯ, ШУТС	БОЯ, БХБЯ, холбогдох ЗДТГ	2007-2010
7	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинг судалж үнэлгээ өгөх	БХБЯ, УМХГ, БОЯ, УХЯ	ЭМЯ, БСШУЯ	2006-2010

Гурав. Орчны эрүүл мэндийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадварийг сайжруулах талаар:

8	Орчны эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг байгууллагын хүчин чадлыг үнэлэх, хүний нөөцийн судалгаа гэрэх	УМХГ, ЭМЯ, БОЯ	Бусад яам, агентлаг	2006-2007
9	Орчны эрүүл мэндийн мэргэжилтний төгсөлтийн дараахь болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох сургалтыг чандаржуулах	БСШУЯ, ЭМШУИС	БОЯ, ЭМЯ	2007-2010
10	Орчны эрүүл мэндийн хяналтын байцаалч, судалгааны байгууллагын судлаач, шинжээчдийг гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар шат дараатай арга хэмжээг авч	БСШУЯ, УМХГ, ЭМЯ, БОЯ, ГХЯ	Холбогдох яам агентлагууд	2007-2010
11	Төрийн сангийн эрдэлээр орчны эрүүл мэндийн чиглэлээр гадаадад мэргэжил дээшлүүлэх мэргэжилтний тоог нэмэгдүүлэх	БСШУЯ, СЯ	Холбогдох яам агентлагууд	2007 оноос
12	Орчны хяналтын, судалгааны лабораториудын зэрэглэл тогтоож шаардлагатай багаж төхөөрөмжөөр хангах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх	УМХГ, ЭМЯ, БОЯ	Холбогдох яам агентлаг	2008-2010
13	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн лабораторийг өргөтгөх зөмөр орчны эрүүл мэнд (хими, физик, биологийн)-ийн Үндэсний лавлагаа-лаборатори байгуулах	ЭМЯ, СЯ	Холбогдох яам	2006-2010
14	Бусуудийн тулгуур төвүүдэд орчны эрүүл мэндийн лаборатори байгуулах асуудлыг судлах	ЭМЯ, УМХГ	БОЯ, аймаг нийслэлийн ЗДТГ	2007-2010
<p>Дөрөв. Орчны бохирдолтыг бууруулан экологийн тэнцвэртэй байдалыг хангах, орчны сөрөг хүчин зүйлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар:</p>				
<p>Ундны цэвэр усны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр</p>				
1	Сум, суурин газрын хүн амын ундны ус хангамжийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд шаардагдах хөрөнгө, нөөцийн нарийвчилсан судалгаа гарган хэрэгжүүлэх	БХБЯ	БОЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2006-2010
2	Төв, суурин газрын гэр хорооллын цэвэр, бохир усны төвлөрөөн шугам сулжээнд холбох цоц арга хэмжээ авч хэрэгжүүлэх	БХБЯ, БОЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	Холбогдох яам агентлаг	2006-2010
3	Усны Үндэсний хөтөлбөрт өөрчилт оруулан 3 дугаар үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	БОЯ, Усны хэрэг эрхлэх газар, Усны үндэсний хороо	Холбогдох яам	2006

	БХБЯ, ЭМЯ, УХЯГ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ	2007-2010
Агаарын бохирдлыг бууруулах талар:			
4	Томоохон хот, сум суурин газрын үндэс усны эх үүсвэрийн бохирдолт, усны чанарын нэрийгчилсэн судалгааг гаргах, голын эй саваг бохирдлоос хамгаалах арга хэмжээ авах, усны чанарыг сайжруулах тоног төхөөрөмжийг үе шаттай суурилуулах		
5	Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр боловсруулж, бохирдлыг бууруулах талсаар эрчимтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх	БОЯ, ТЭХЯ, СТАЖА, нийслэлийн ЗДТГ	Холбогдох аям
6	Хот, суурин газарт гэр хорооллын эйг өрхийн зуухны хийцийг сайжруулах, коксжуулсан шахмал түлш үйлдвэрлэж нэвтрүүлэх	ТЭХЯ, БОЯ	2006-2010
7	Хот, суурин газрын төлөвлөлт, хот байгуулалтын экологийн менежментийг боловсруулж болгоход чиглэсэн шат дараатай арга хэмжээ авах	БХБЯ, ЭМЯ, УХЯ, нийслэлийн ЗДТГ	2006-2008
8	Нийслэл аймгийн төвд цэцэрлэгт хүрээлэн, толгоомын талбай, нээлтэй орон зай, унадаг дүүгуйгаар явах, ахлах зам байгуулах зурга, төсөл боловсруулж хэрэгжүүлэх	ЭМЯ, БОЯ, нийслэлийн ЗДТГ	2006-2015
9	Хар тусгалга агуулахагүй түлш импортлох, хэрэглэх арга зүйн орчин бүрдүүлэх	ТЭХЯ	2008-2010
10	Стандартын шаардлага хангалтгүй автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулалгүй байх арга хэмжээг авах	СТАЖА, ЦЕГ	2006-2010
11	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө багатай дэвшилтэт технологий бүхий хийжиг, дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх	УХЯ, БОЯ	2006-2015
12	Хүнд үйлдвэр, уурхайн ажиллагай, үйлдвэрлэлийн явцад ялгарч байгаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө бүхий хог хаягдал, утаа, хорт бодисын хэмжээг багасгах, цэвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	БОЯ, ЭМЯ, УХЯ	2006-2010
Хатуу, шингэн хаягдлын менежментийг сайжруулах талар:			
13	Ариун цэврийн байгууламжийн талсаар дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	БОЯ	2006-2015
14	Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүү, техник технологийн шинэчлэлийн асуудлыг шат дараатай шийдвэрлэх	Нийслэлийн ЗДТГ	2006-2007
15	Төв суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан инженерийн байгууламж бүхий хотын нэгдсэн цэг байгуулах зөвсөр, журалм боловсруулж түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	БХБЯ	2006-2010

16	Улаанбаатар хотод эмнэлгийн хог хаягдлыг устгах нэгдсэн байгуулалж байгуулах төсөл боловсруулалт хэрэгжүүлэх	ЭМЯ, БОЯ БХБЯ, УИХГ	ИТХ, ЗДТГ БОЯ	2005-2008 2006-2010
17	Хот суурин газрын бохир ус цэвэрлэх байгуулалжийн цэвэрлэгээний үр дүнг сайжруулах дэвшилт эргэ технологийг нэвтрүүлэх	БХБЯ, ЗДТГ	Холбогдох яам, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд	2006-2015
18	Зуслалгийн төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулж айл өрх, аж ахуйн нэгжийн ус хангамж, ариун цэврийн байгуулалжийг өнөөчтэй шийдвэрлэх, хог хаягдал чигүүлэх, хадгалэх, зайлуулах үйл ажиллагааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх ажлыг зохион байгуулах	Хөдөлмөрийн эюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах талсаар: НХХЯ, ЭМЯ	Холбогдох яам	2007-2010
19	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх, тандах, мэдээлэх ажлыг боловсронгуй болгох	НХХЯ, ТЭХЯ, ЭМЯ	ҮХЯ, холбогдох яам	2008-2010
20	Уушга тоосмаг (пневмококк) өвчнийг бууруулахад чиглэсэн дэд хөтөлбөр боловсруулан энэ чиглэлээр ДЭМБ, ОУХБ-тай хамтран ажиллах	НХХЯ, ЭМЯ	УИХГ, аймгийн ЗДТГ, Ажил олгогч, эздийн холбоо	2006-2010
21	"Эрүүл ажлын байр"-ны санзачилгыг үндэсний хэмжээнд өргүүлж, үйлдвэрлэлийн онцролт тохирсон эрүүл ажлын байрны болзол, шалгуурыг боловсруулан мөрдүүлэх, урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах	НХХЯ, ЭМЯ	Холбогдох яам	2008-2015
22	Мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, магадлах чэдвэхийг сайжруулах эргэ хэмжээ авэх	НХХЯ ЭМЯ, ҮХЯ	Холбогдох яам Үйлдвэр, аж ахуйн газар, агентлагууд	2006-2010
23	Уул уурхай, барилга, барилгын материал, эрчим хүчний салбарын жижиг, дунд үйлдвэрийн хөдөлмөрийн нөхцөлийг ажиллагсад эрүүл мэндтэй холбоон судалж хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах эргэ хэмжээг авч хэрэгжүүлэх	СЯ, ҮХЯ, НХХЯ, ЭМЯ	Холбогдох яам, агентлагууд, үйлдвэр, аж ахуйн газар	2007-2015
24	Ажлын байрны нөхцөлийг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд зэрцүүлэх хөрөнгийг нэмэгдүүлэх	Химийн эюулгүй байдлыг сайжруулах, хордлогоос урьдчилан сэргийлэх талсаар: БОЯ	Холбогдох яам	2007-2008
25	Химийн эюулгүй байдлын менежментийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	ХХААЯ, БОЯ	ҮХЯ, холбогдох яам	2007-2008
26	Пестицидийн менежментийн боловсронгуй болгож хортон шавьж, мөргөчдийн устгал, ариутгал, халдваргүйтлийн хүмий эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлдэггүй шинэ, дэвшилтэт технологийг практикт нэвтрүүлэх			

27	Хүн амыг хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, хордлогын бүртгэл, мэдээлэл, тандалт, судалгааны салбар дундын төв байгуулах асуудлыг судлах	БОЯ, БХЯ, ЭМЯ	Холбогдох яам	2006-2008
28	Биологийн идэвхт үйлчилгээтэй хүнс, гоо сайхны бүтээгдэхүүний бүртгэл, мэдээлэл болон түүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд тавих хяналтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	ХХААЯ, УМХГ, ЭМЯ	Холбогдох байгууллага, агентлагууд	2006-2015
29	Монголын уламжлалт хоол хүнсний эрүүл ахуй, тэжээлэг чанар, аюулгүй байданд судалгаа явуулах, экологийн цэвэр, аюулгүй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	ХХААЯ, УМХГ, ҮХЯ	Холбогдох байгууллага	2006-2008
30	Импортын бүтээгдэхүүн ялангуяа хүнсний ногоо, жимс болон бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах пестицидийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнд тавих хяналтыг сайжруулах	ХХААЯ, УМХГ, ҮХЯ	Холбогдох байгууллага	2006-2008
Тав. Хүн амд орчны эрүүл мэндийн зохистой мэдээлэл, дадал, хандлага, зан үйл хэвшүүлэх замаар орчны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.				
1	Орчны эрүүл мэндийн асуудлаар хүн амын тодорхой бүлгийн мэдлэг, дадалаа, хандлагад судалгаа явуулж үнэлгээ өгөх	ЭМЯ	БСШУЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2006-2007
2	Олон нийтийн радио, телевизээр орчны эрүүл мэндийн чиглэлээр явуулах мэдээлэл, сургалт, сурталчилгааны давтамж, хугацааг нэмэгдүүлэх	ЭМЯ, УМХГ, БОЯ, БСШУЯ	Хэвлэл мэдээллийн байгууллага	2006-2010
3	Байгаль орчны сурталчилгааны "Эко" сүвгийг Эрүүл мэнд-Эко болгон өргөжүүлэх	БОЯ, ЭМЯ	Хэвлэл мэдээллийн байгууллага	2006-2010
4	Сургуулийн өмнөх насны хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралчдад орчны эрүүл мэндийн талаар олгох сургалтын чиглэл, хөтөлбөр гарган мөрдүүлэх, сургалтыг системтэй явуулан үр дүнг тооцох	БСШУЯ	Хэвлэл мэдээллийн ЭМЯ, УМХГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2006-2010
5	Орчны эрүүл мэндийн тодорхой чиглэлээр гарын авлага, сургалт, сурталчилгааны материал бэлтгэх нийтийн хүртээл болгох, орчны эрүүл мэндийн чиглэлээр сургалт явуулах сургалч багш бэлтгэх ажлыг зохион байгуулах	ЭМЯ, БСШУЯ	Холбогдох яам, агентлагууд	2006 - 2010
6	Байгаль орчинтой харьцах уламжлалт зан үйл, арга ухааныг сурталчилган дэлгэрүүлэх ажил зохиох	ЭМЯ, БОЯ	БСШУЯ, ТББ-ууд	2006 - 2010
7	Эрүүл орчин бүрдүүлэхэд чиглэсэн хамт олны санаачилгыг дэмжих эрүүл хот, дүүрэг, сум, ахуйн байр, сургууль, хамт олон болох хөдөлгөөнийг өргүүлэх	ЭМЯ, НХХЯ, ҮХЯ, БСШУЯ	Ажил олгогч, эздийн холбоо	2006-2010

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> змхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн сэдэн

№ 265958  
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 3.5

№ 329487

